

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2014 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар

2014 он

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Соёлын өвийн төвийн захиралтай 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан Үр дүнгийн гэрээ, Соёлын өвийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөны дагуу 2014 онд хийгдсэн ажлыг тайлагнаж байна.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдтай тус төвийн захирлын байгуулсан үр дүнгийн гэрээнд 2 тусгай арга хэмжээ, мөн 15 нийт арга хэмжээ тусгагдсаныг дараах байдлаар хийж гүйцэтгэв. Тусгай 2 арга хэмжээ бүгд бүрэн биелсэн бөгөөд 15 нийт арга хэмжээнээс 1.4, 3.4 гэсэн 2 ажил биелэгдээгүй байна. Учир нь 1.4 тусгагдсанажил болох 2014 оны 11 дүгээр сард хэвлэгдэх ёстой байсан Завхан аймгийн нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал цувралын санхүүжилт тасарсаны улмаас хэвлүүлж чадаагүй байна. Мөн 3.4 тусгагдсан Түүх, соёлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх 3 үл хөдлөх дурсгалыг хаягжуулах ажлын санхүүжилтыг Их бурхант цогцолборыг сэргээн засварлах ажилд шилжүүлсэний улмаас тус тус хийгдээгүй болно.

НЭГ. Байгууллага (Соёлын биет өвийг хамгаалах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

1.1 Төв аймгийн зүүн болон урд талын 15 сумдын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах

1921 оноос өмнө Түшээт хан аймагт багтаж байсан. 1923 оны 10 дугаар сараас Богдхан уулын аймаг, 1931 оноос Төв аймаг гэж нэрлэгдэх болжээ. 1931-1942 онуудад аймгийн захиргаа Улаанбаатарт хавсрагдаж байснаа 1942 оноос одоогийн Зуунмод хотод төвлөрсөн байна. Аймгийн нутаг дэвсгэрт 74,042.37 км² хэмжээтэй

бөгөөд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот байрладаг, харилцаа холбоо, авто, төмөр зам зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц харьцангуй хөгжсөн. Нийт 27 сумтай.

Тус төвөөс 2012 оноос эхлэн Төв аймгийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн тоолох ажлыг хийж эхэлсэн.

- 2012 онд аймгийн Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Цээл, Угтаалцайдам, Заамар зэрэг 7 сум,
- 2013 онд Аргалант, Баянхангай, Баянцогт, Лүн, Өндөрширээт зэрэг 5 сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан юм.
- 2014 онд үлдсэн 15 сумын нутагт дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсанаар тус аймгийн 27 сумын нутгийг бүрэн хамруулан ажиллаж дуусгав.

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн, судлаачид урьдчилан төлөвлөсний дагуу 2014 онд 5000 км аялж нийт 114 орчим дурсгалт газрыг давтан болон шинээр илрүүлж улсын бүртгэлд бүртгэн авч тэдгээрийг 10 орчим GB дүрс бичлэг, 30 орчим кадр хальсны зураг, 5500 гаруй дижитал гэрэл зургаар баримтжуулсан байна. Мөн хөдөө орон нутгийн холбогдох хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа.

Сумын нэр	Гэрэл зураг болон Дүрс бичлэг	хэмжээ
2012 он		
Баянчандмань	77 ш	361 MB
Борнуур	696 ш	2.89 GB
Жаргалант	452 ш	2.14 GB
Сүмбэр	317 ш	982 MB
Цээл	304 ш	1.62 GB
Угтаалцайдам	312 ш	1.64 GB
Заамар	611 ш	3.08 GB
Нийт	2769 ш	12,713 GB
2013 он		
Аргалант	138ш	1.27 GB
Баянхангай	213 ш	1.93 GB
Баянцогт	353 ш	3.04 GB
Лүн	524 ш	4.31 GB
Өндөрширээт	1671 ш	15.7 GB

Нийт	2899	26.25 GB
2014 он		
Эрдэнэсант	519 ш	2.53 GB
Дэлгэрхаан	1082 ш	4.85 GB
Бүрэн	879 ш	6.59 GB
Батсүмбэр	551 ш	3,28 GB
Эрдэнэ	367 ш	2.70 GB
Мөнгөнморьт	644 ш	4.54 GB
Баяндэлгэр	595 ш	3.98 GB
Архуст	317 ш	2.36 GB
Баянжаргалан	289 ш	2.43 GB
Баян	364 ш	2.59 GB
Сэргэлэн	482 ш	3.92 GB
Баянцагаан	608 ш	4.66 GB
Баян-Өнжүүл	507 ш	4.59 GB
Алтанбулаг	542 ш	4.12 GB
Нийт	5546 ш	62,2 GB

2014 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл 45 хоногийн хугацаанд Соёлын өвийн төвийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, техникийн ажилтан П.Чинбат, гэрээт ажилтан П.Ууган-Эрдэнэ, жолооч Б.Эрдэнэчимэг, Төв аймгийн музейн тайлбарлагч С.Ариунзул нар тус аймгийн Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн, Батсүмбэр, Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Баянжаргалан, Баян, Зуун мод, Сэргэлэн, Баянцагаан, Баян-Өнжүүл, Алтанбулаг сум гэсэн маршрутаар 5000 км аялж нийт 114 орчим дурсгалт газрыг давтан болон шинээр илэрүүлж улсын бүртгэлд бүртгэн авч тэдгээрийг 10 орчим GB дүрс бичлэг, 30 орчим кадр хальсны зураг, 5500 гаруй дижитал гэрэл зургаар баримтжуулсан байна. Мөн хөдөө орон нутгийн холбогдох хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа.

Дээрх хуримтлуулсан мэдээллийг эмхлэн цэгцэлж, улсын нэгдсэн бүртгэл – мэдээллийн санд хадгалахаар ажиллаж байна. /Дэлгэрэнгүй тайлан УНБМСанд хадгалагдаж байна./

1.2 Өмнөговь аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэнбаримтжуулах

1921 оноос өмнө Говь мэргэн гүний хошуу, Балдан засгийн хошуудад 1923 оноос Богд Хан уул, Цэцэрлэг Мандлын аймгуудад хамаарч байгаад 1931 онд Өмнөговь аймаг гэж нэрлэгдэх болжээ. Тус аймаг нь газар нутгийн хэмжээгээрээ хамгийн том аймаг бөгөөд 165,380.47 км² хэмжээтэй. Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий. Нийт 15 сумтай.

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн, судлаачид урьдчилан төлөвлөсний дагуу 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 30 хоногийн хугцаанд Соёлын өвийн төвийн Түүх, Соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, Т.Эрдэнэцогт, гэрээт ажилтан А.Цоож, жолооч Б.Эрдэнэчимэг, Өмнөговь аймгийн музейн ажилтан н.Жаргалбат нар тус аймгийн Баян-Овоо, Номгон, Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй гэсэн 7 сумын нутгаар 6700 орчим км аялж нийт 132 дурсгалт газрыг улсын бүртгэлд хамруулан, газар зүйн солбицолыг тогтоон бүртгэв.

Бүртгэл судалгаанд хамрагдсан дурсгалуудыг 35 орчим минутын дүрс бичлэг, 45 орчим кадр хальсны зураг, 6100 гаруй дижитал гэрэл зургаар баримтжуулж авлаа. Мөн хөдөө орон нутгийн холбогдох хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа. /Дэлгэрэнгүй тайлан УНБМСанд хадгалагдаж байна./

Сумын нэр	Гэрэл зураг болон Дүрс бичлэг	хэмжээ
Баяновоо	373 ш	3.06 GB
Номгон	2197 ш	17.1 GB
хүрмэн	1118 ш	8.71 GB
Баяндалай	598 ш	4.57 GB
Ноён	1034 ш	9.57 GB
Гурвантэс	1295 ш	9.92 GB

Сэврэй	946 ш	7.16 GB
Нийт	7561 ш	60.09 GB

1.3 Дэл уулын орчмын түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулан авсан материал, хэрэглэгдэхүүнийг боловсруулах

2011 онд Соёлын өвийн төвийн бүртгэл судалгааны баг Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулах үеэр Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл уулын орчимд ажиллан энэ орчмын хадны зураг зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын орчинд дүн шинжилгээ хийж нэн даруй хамгаалах нь зүйтэй хэмээн үзэж аймгийн музей болон орон нутагтай хамтран болж 2 жилд дараалан ажилласан билээ.

2014 онд өмнө онуудад цуглуулсан баримт хэрэглэгдэхүүнийг нэгтгэн боловсруулж СӨУНБМСанд хадгаламжийн нэгж үүсгэн архивлан хадгаллаа. Мөн 2013 оны үйл ажиллагааны тайлан, гэрэл зураг, “Дэл уулын түүх, соёлын дурсгал” баримтат кино болон зарим хадны зураг, бичээсийн дардас зэргийг www.deluul.monheritage.mn веб сайтанд байрлуулж олны хүртээл болголоо.

1.4. “Завхан аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цуврал XI дэвтэр”, “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийг хэвлэх

“Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” цуврал каталогийн XI дэвтэр, “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн 7 дахь дугаарыг хэвлэхээр төлөвлөсөн боловч төсвийн санхүүжилт танагдсан шалтгаанаар энэ ажил хийгдээгүй болно.

1.5. Музейн үзмэр болон үл хөдлөх дурсгалуудыг 3D-ээр сканнардан, бүртгэн баримтжуулах

1.5.1 Богд хааны ордон музейн 3 үзмэрийг 3D-ээр сканнардан, бүртгэн баримтжуулах ажил

Тус төв 2008 оноос түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалыг өндөр нарийвчлал бүхий 3D технологиор бүртгэн баримтжуулах ажлыг эхлүүлсэн. Энэ хугацаанд Японы Дошиша их сургуулийн Соёлын өвийн мэдлэг судалгааны төвтэй хамтын ажиллагаа тогтоож мэргэжилтэн бэлтгэж ирсэн. 2012 онд ССАЖ-ын яамны хөрөнгө оруулалтаар Artex Eva 3D сканнер, 2013 онд Япон улсын ЗГ-ын соёлын

буцалтгүй тусламжаар ViVid 9i non-contact 3D сканнерыг тус тус авч 2013 оноос эхлэн 3D баримтжуулалтын ажлыг дотоодын нөөц бололцоогоор бие даан хийж байна. Мөн 2014 оноос 3D баримтжуулалтын ажлыг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хийж эхлээд байна.

Энэхүү ажлын хүрээнд 2014 онд Богд хааны ордон музейтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж 3 ш цутгуур бурханыг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулж СӨУНБМСанд хадгаллаа.

3D-ээр баримтжуулсан бурхад:

1. МАНАЛ

Хувийн дугаар: **24.1.261**

Ерөнхий бүртгэлийн дэвтэр дэхь дэс дугаар: **168**

Төрөл зүйл: **4.3. Цутгамал**

Өндөр: **30см**

2. ЗОНХАВ

Хувийн дугаар: **24.1.209**

Ерөнхий бүртгэлийн дэвтэр дэхь дэс дугаар: **178**

Төрөл зүйл: **4.3. Цутгамал**

Өндөр: **15см**

3. ТАВАН ХААН /Түгжий жалбуу/

Хувийн дугаар: **24.1.368**

Ерөнхий бүртгэлийн дэвтэр дэхь дэс дугаар: **119**

Төрөл зүйл: **4.3. Цутгамал**

Өндөр: **11см**

1.5.2. Сүхбаатар аймагт орших Хөхлийн ширээ, Ламтын хүн чулуу, Дарьгангын Алтан овооны зэрэг Монголын үеийн хүн чулуун 6 дурсгалыг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах ажил.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн урагш 40 гаруй км-т Ламт хэмээх уулын зүүн хормойд байх 13-14 дүгээр зуунд хамаарах “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалт”-ын “Улсын хамгаалалтад” орсон түшлэгтэй исэр сандалд сууж байгаа дүрстэй 2 хүн чулуун хөшөөг 3D-ээр сканнердаж бүртгэн баримтжуулах ажлыг 2014 оны 06 дугаар сарын 3-ны өдрөөс 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Бүртгэн баримтжуулах багт тус төвийн програмист Б.Алтансүх, Ж.Даваацэрэн, техникийн ажилтан П.Чинбат, жолооч Б.Эрдэнэчимэг нар ажиллав.

3D лазер хэмжилтийн ажлыг Konica Minolta VIVID 9i 3D сканнер, Dell Precision маркийн зөөврийн компьютер, “Konica Minolta Polygon editing tool software” болон “Rapidform Geomagic XOS” програм хангамжуудыг тус тус ашиглан хийлээ.

Хүн чулууныг зөөлөн хөрстэй аюулгүй газар зөөж байрлуулан дээгүүр нь нарны шууд тусгалыг хаах сүүдрэвч барьж дараа нь 3D хэмжилтийг хийв.

Хээрийн судалгааны ажлын дүнд цуглуулсан хүн чулууны 3D хэмжилтийн мэдээллийг **Rapidform Geomagic XOS** програм ашиглан анхан шатны байдлаар боловсруулж СӨУНБМСанд цахим хэлбэрээр хадгаллаа.

1.6. Улсын музейнүүдийн сан хөмрөгийн улсын тооллогын дүн мэдээг авах, нэгтгэх

Тооллогын ажлыг БСШУЯ /хуучин нэрээр/, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн хороо хариуцан эхлүүлсэн. Яамны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, хороо 2012 оны 11 сард татан буугдсан зэрэгтэй холбогдуулан ССАЖЯ, Соёлын өвийн төв, аймгийн Засаг дарга нар зохион байгуулж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн соёл, урлаг хариуцсан улсын байцаагч, гэрээт байцаагчид хяналт тавьж ажиллаа. Соёлын өвийн төвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангаас “Улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2012-2013 онуудын улсын тооллогын дүнгийн судалгаа”-ны гурван төрлийн маягт боловсруулан түүний дагуу тооллогын дүн мэдээ нэгтгэх, музейнүүдээс холбогдох материалуудыг хүлээн авах ажлыг хариуцан гүйцэтгэлээ.

БСШУ-ны сайдын /хуучин нэрээр/ 74 дүгээр тушаалын дагуу Музейн сан хөмрөгийн улсын тооллогын төв комиссын бүрэлдэхүүнийг тус яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзунгаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байгаад, яам шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан ССАЖ-ын сайдын 2012 оны А/57 дугаар тушаалаар тус яамны Соёлын өвийн хэлтсийн дарга Ц.Цэндсүрэнгээр ахлуулан 12 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Улсын тооллогын салбар комиссын бүрэлдэхүүнийг улсын 11 музейд Соёл, урлагийн хорооны /татан буугдсан/ даргын тушаалаар, байгууллагын 7 музейд харьяа төрийн

захиргааны төвбайгууллагын тушаалаар, орон нутгийн музейд аймгийн Засаг даргын захирамжаар тус тус байгуулсан.

Нийтдээ 2012-2014 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогод 301 байгууллага хамрагдаж тооллогын төв болон салбар комисст нийт 376хүн ажилласан байна.

Тооллогын ажил 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдөр улс, аймгийн музейнүүдэд зэрэг эхлүүлсэн. БСШУ-ны сайдын /хуучин нэрээр/ 2012 оны А/411 дүгээр тушаалаар улсын тооллогыг 2013 оны 01 дүгээр сарын 05-нд дуусгаж, дүн мэдээг 2013 оны 10 дугаар сарын 01-ны дотор ирүүлэх, аймгийн музей болон орон нутаг судлах танхимын тооллогыг 2013 оны 02 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхээр заасны дагуу аймгийн музейн тооллогын дүн мэдээг 2013 оны 11 дүгээр сарын 05-нд, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй музейн дүнг 12 дугаар сарын 16-нд ССАЖ-ын сайдын хуралдаанд тус тус танилцуулсан болно.

Энэ удаагийн тооллогод 2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод хамрагдсан 35 музей дээр Монгол банкны Эрдэнэсийн сан, Шанхын баруун хүрээ хийд, Төвхөн хийд, Дорнод аймгийн Ялалтын музей, шинээр байгуулагдсан Хархорум музей /2011/, Хөшөө цайдам музей /2011/, Төрийн түүхийн музей /2011/ гэсэн 7 музей нэмэгдснээр нийт 42 болсон байна. Үүнд улсын 9 музей, байгууллагын 7 музей, аймгийн 23 музей, хувийн өмчлөлийн 1 музей, сүм хийд 2 болон 19 аймгийн 257 Орон нутаг судлах танхим нийтдээ 298 байгууллага хамрагдлаа.

Д/д	Байгууллагын нэр	Тоологдох ёстой үзмэр		2012-2013 онд тоологдсон үзмэр		
		дэс	тоо	дэс	тоо	Иж бүрдэл б.х.тоо
1	Монголын үндэсний музей	16582	49010	18897	55572	74306
2	Байгалийн түүхийн музей	5787	7437	6094	7803	7803
3	Богд хааны ордон музей	4187	8703	4202	8631	35779

4	Дүрслэх урлагийн музей	7869	18171	9771	16561	18913
5	Чойжин ламын сүм музей	980	6211	988	6370	137857
6	Уран зургийн галерей	3274	3730	3341	3590	4125
7	Монголын театрын музей	6595	9499	6568	9494	9494
8	Төрийн түүхийн музей	654	1079	654	1079	1351
9	Хархорум музей	877	1647	542	1052	1052
10	Хөшөө цайдам музей	131	161	145	175	236
11	Монгол цэргийн музей	3308	8761	3304	8262	9274
12	Үндэсний номын сан	630	630	516	516	135634
13	Улаанбаатар хотын музей	758	3339	746	3340	3521
14	ШУА-н Палеонтологийн төв	208	292	232	320	3513
15	ШУА-н Археологийн хүрээлэн	885	5909	1020	6893	6893
16	Архангай аймгийн музей	1655	4099	1696	3866	4637
17	Баян-Өлгий аймгийн музей	1237	5042	1298	5072	6052
18	Баянхонгор аймгийн музей	2759	8388	4074	10522	65811
19	Булган аймгийн музей	2308	4189	2285	4442	4442
20	Говь-Алтай аймгийн музей	1577	2530	2489	2489	6267
21	Говьсүмбэр аймгийн музей	507	671	507	691	1131
22	Дархан-Уул аймгийн музей	905	1230	882	1240	1493
23	Дорноговь аймгийн музей	2165	5802	2180	5533	6455
24	Данзанравжаагийн музей	258	1461	258	1461	1515
25	Дорнод аймгийн музей	1542	3497	1636	3645	4041

26	Дорнод. Ялалтын музей	348	442	354	448	684
27	Дундговь аймгийн музей	2981	4655	3017	4475	5596
28	Завхан аймгийн музей	2348	3482	2313	10174	11760
29	Орхон аймгийн музей	978	1436	1155	1601	2177
30	Өвөрхангай аймгийн музей	1103	2479	1200	2379	2538
31	Өмнөговь аймгийн музей	1026	2400	1037	2309	3105
32	Сүхбаатар аймгийн музей	656	1767	1130	2025	2901
33	Сэлэнгэ аймгийн музей	2292	3359	2303	3201	3412
34	Төв аймгийн музей	3314	5629	2861	5381	6620
35	Увс аймгийн музей	1361	7777	2673	5679	28451
36	Ховд аймгийн музей	875	2977	892	2977	5007
37	Хөвсгөл аймгийн музей	1839	3957	1835	3634	4158
38	Хэнтий аймгийн музей	1138	2164	1150	2080	3531
39	Эрдэнэ зуу музей	1807	7906	1823	7464	7633
40	Шанхийн баруун хүрээ хийд			671	3686	3686
41	Төвхөн хийд			63	395	395
42	Эрдэнэсийн сан			417	1151	1190
Дүн		73122	162908	99219	227678	644439

Үзмэрийн шинэчилсэн үнэлгээ хийв. 1990 онд музейн үзмэрийн үнэлгээг швецарь франкад шилжүүлэх ажил хийснээс хойш музейн үзмэрийн үнэлгээ хийгдээгүй байсанд дүгнэлт хийж 2012-2013 оны улсын тооллогоор үзмэрийн үнэлгээний зөрүүг гарилгах зорилгоор улсын тооллогын төв комиссоос “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-ын төслийг боловсруулж, музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, холбогдох мэргэжилтнүүдийн санал авч жишиг үнийг жагсаалт гаргаж Төв аймгийн музей,

Эрдэнэ-зуу музей, Хөшөө цайдам музей, Хар хорум музей, Өмнөговь аймгийн музей, Дүрслэх урлагийн музей зэрэг газруудад туршилт судалгаа хийх ажлыг зохион байгуулсан. Үнэлгээний журмыг Сангийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 140 дүгээр тушаалаар “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”, түүний нэгдүгээр хавсралтаар “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ыг батлуулж, шинэчилсэн үнэлгээ тогтоох ажил хийгдлээ. Соёлын өвийн төвөөс бүртгэлийн үнэ тогтоох ажлыг хялбар шуурхай болгох үүднээс тооллогын бүртгэлийн “Register” програмд нэмэлт хийж бүртгэлийн үнийн хэсгийг дахин програмчлан шинэчлэг, update-ийг бүх музейнүүдэд суулгасан.

Тооллогын ажлын удирдамжийн дагуу музейн үзмэрийн ерөнхий бүртгэлийн дэвтрийн хуулбар хувь болон “Register” програмын цахим мэдээллийн санг СӨУНБМСанд нэгтгэж байна.

Дүд	Музейн нэр	Хуучин бүртгэлийн үнэ	Шинэчилсэн дансны үнэ
1	Байгалийн түүхийн музей	157,263,078	316,399,029
2	Богд хааны ордон музей	1.800.357.954	14.377.085.598
3	Дүрслэх урлагийн музей	1846462900	26,531,729,500.00
4	Чойжин ламын сүм музей	1,359,850,908	3,453,589,310
5	Уран зургийн галерей	772,881,464	15,061,655,700
6	Монголын театрын музей	57,200,633	776,169,020
7	Төрийн түүхийн музей	369.354.725	3.407.292.940
8	Хөшөө цайдам музей	30,000,000	134.750.000
9	Хархорин музей		2,896,160,013
10	Монгол цэргийн музей	237,985,528,44	1,701,484,759
11	Улаанбаатар хотын музей	24,017,560	484,309,819
12	Монголын Үндэсний номын сан		2,974,884,400
13	Палеонтологийн төв		1,227,860,000
14	Архангай аймгийн музей	106,142,194	997,933,588
15	Баян-Өлгий аймгийн музей	36,020,138	1,476,877,350
16	Баянхонгор аймгийн музей	192,502,938	871,485,853
17	Булган аймгийн музей	20,717,600	326,396,0
18	Говь-Алтай аймгийн музей	25,262,611	905,009,600

19	Говьсүмбэр аймгийн музей	29,881,175	40,785,225
20	Дархан-Уул аймгийн музей	40,078,850	547,951,000
21	Дорноговь аймгийн музей	114,964,581	649,624,600
22	Данзанравжаагийн музей	825,274,300.00	1,392,620,000.00
23	Дорнод аймгийн музей	81,325,988	802,565,340
24	Дорнод. Ялалтын музей	30,535,269,8	84,973,300
25	Дундговь аймгийн музей	69,360,338	837,506,550
26	Завхан аймгийн музей	158,153,893	1,087,252,688
27	Орхон аймгийн музей	58,124,710	627.030.500
28	Өвөрхангай аймгийн музей	162,799,804	1,124,640,200
29	Өмнөговь аймгийн музей	75,491,538	756,319,780
30	Сүхбаатарын аймгийн музей	65,979,770	770,625,015
31	Сэлэнгэ аймгийн музей	163,996,543	1,964,925,410
32	Төв аймгийн музей	97,298,560	864,050,760
33	Увс аймгийн музей	46,604,361,60	3,409,578,100
34	Ховд аймгийн музей	81,746,727	989,815,500
35	Хөвсгөл аймгийн музей	32,333,915.00	827,272,000
36	Хэнтий аймгийн музей	88,338,892	910,387,522
37	Эрдэнэ зуу музей	848,722,690	7,305,931,900
	НИЙТ	7,622,194,298.00	84,042,372,831.00

1.7. Гандантэгчинлэн хийдийн бурхан шашны холбогдолтой, түүх, соёлын дурсгалд тооцогдох эд өлгийн зүйлсийн тооллого явуулах, бүртгэн баримтжуулах

Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдэд монголын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах бурханы шашны олон мянган шилдэг дурсгалууд хадгалагдаж байдаг билээ. Тус хийдэд улсын тооллого хамгийн сүүлд 1987 онд явагдсанаас хойш 26 жилийн дараа улсын тооллого хийгдлээ.

ССАЖ-ын сайдын 2013 оны А/117 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2-д заасны дагуу Соёлын өвийн төв түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх мэргэжил арга зүйгээр ханган, тооллогын ажлыг удирдан, зохион байгуулан ажиллалаа.

Улсын тооллогыг чанартай, үр дүнтэй зохион байгуулан ажиллахад анхаарч дараах бэлтгэл ажлуудыг хийсэн. Үүнд:

- ССАЖЯамнаас Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогын удирдамж, тооллогод шаардагдах 35.640.000 төгрөгийг шийдвэрлэсэн;

- Соёлын өвийн төвөөс тус хийдийн ерөнхий бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийг боловсруулан зохиосон;

- Тооллогоор хөтөлсөн “Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэл”-ийн дэвтрийг хэвлүүлсэн зэрэг бэлтгэл ажлуудыг 2012 оны сүүлчээс эхлэн 2013 оны эхний 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэлээ.

- Тооллого эхлэхийн өмнө тус хийдийн захиргаа, ССАЖЯам, Соёлын өвийн төв, музейн төлөөллөөс оролцсон хурлыг 2 удаа зохион байгуулсан.

- Гандантэгчэнлийн хийдийн Улсын тооллогын комиссын гишүүдэд зориулан “Улсын тооллого явуулах тухай” сургалтыг зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан.

ССАЖ-ын сайдын 2013 оны А/117 тоот тушаалын дагуу Гандантэгчэнлин хийдийн захиргаа, Соёлын өвийн төв, Үлэг гүрвэлийн төв музей, Байгалийн түүхийн музейгээс томилогдсон улсын тооллогын комисс Гандантэгчэнлийн хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн улсын тооллогыг 2013 оны 04 дүгээр сарын 16-наас эхлэн 2014 оны 12 дугаар сарын 01-нийг дуустал нэг жил, долоон сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ.

2013-2014 оны улсын тооллогод 1987 оны улсын тооллогын бүртгэлийн дэвтрийг баримтлан тоолж бүртгэлээ. 1987 оны улсын тооллогоор 4970 дэсийн 21193 бурхан шүтээн, эд өлгийн зүйлс тоологдсон байна.

1987 оны тоон дүнгээс нэг дахин их хэмжээний бурхан шүтээн, эд өлгийн зүйлс тоологдсон шалтгаанаар улсын тооллого 7 сараар сунгагдсан юм.

Мөн Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогоор тус хийдэд хадгалагдаж байсан урьд өмнө бүртгэлд тусгагдаагүй байсан түүх, соёлын дурсгалд хамаарах **23100** бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг шинээр бүртгэсэн нь монголын соёлын өвийн тоон мэдээллийг баяжуулж түүх, соёлын дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан томоохон ажлын нэг боллоо.

1. Гандантэгчэнлин хийдийн 2012-2013 оны улсын тооллогоор нийт **8319** дэсийн **45937** ширхэг бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн тоолж бүртгэлээ.
2. Тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг төрөл зүйлийн үзүүлэлтээр харуулбал:

Цутгамал -1558 дэсийн 2758 ш

Хөөмөл – 1184 дэсийн 4264 ш

Шавар баримал – 1660 дэсийн 14606 ш

Сийлбэр -345 дэсийн 662 ш

Танка зураг - 2762 дэсийн 21334 ш

Зээгт наамал – 128 дэсийн 636 ш байна.

3. Бүртгэлгүй байсан **3451** дэсийн **23100** бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг шинээр тоолж бүртгэлээ. Шинээр бүртгэгдсэн бурхан, шүтээний дотор түүх, соёлын үнэ цэнэтэй:
4. Хуучин бүртгэлтэй байсан **4868** дэсийн **22837** бурхан, шүтээн эд өлгийн зүйлийн бүртгэл тоологдсон.
5. Солигдсон бурхан шүтээн 8 ширхэг байна.
6. Хулгайд алдагдсныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлсэнурьдчилсан байдлаар 130 бурхан шүтээний зүйлс байна.

Улсын тооллого дараах процедур дараалалтай явагдсан ба дуган, дацанд тооллого эхлүүлэх, гүнгэрваа нээх онгойлгох үед видео бичлэг тогтмол хийж баримтжуулсан болно. Тооллогын комиссын гишүүд тооллого явуулах удирдамжийн үндсэн чиглэлийн заалтуудыг мөрдлөг болгон ажилласан

1-рт: Бурхан шүтээн, эд өлгий зүйлсийг нэг бүрчлэн цэвэрлэх, тоос шорооноос нь салгах, цэвэрлэх

2-рт: Бурхан шүтээн, эд өлгий зүйлсийг нэг бүрчлэн нүдээр үзэж, бүртгэн тоолж, 1987 оны бүртгэлийг шинэчлэн сайжруулах, түүх, соёлын дүрсгалт зүйлийг шинээр бүртгэлд хамруулах

3-рт: Хувийн дугаарын асуудлыг шийдвэрлэн, бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн биет дээр дугаарыг зохих журмын дагуу бичих, оёх, зүүх

4-р: Бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн гэрэл зураг авах

5-рт: Бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах

6-рт: Гар бичмэл бүртгэлийг цахим хэлбэрт оруулах

Тооллогод байнга ажилласан музейн ажилтнуудтай “Хариуцлагын гэрээ” байгуулсан.

ССАЖЯ, Гандантэгчэнлин хийдийн захиргаанаас улсын тооллогыг чанартай үр дүнтэй явуулахад анхаарч шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн. ССАЖ-ын

сайдын 2013 оны А/117 тоот тушаалд заасны дагуу Соёл, урлаг хөгжүүлэх сангаас хийдийн улсын тооллогод зарцуулах 35.640.000 төгрөгийг Соёлын өвийн төвд шилжүүлснийг 2013 оны 04 дүгээр сарын 16-наас 2014 оны 04-р сарын 15 хүртэл зарцуулагдсан.

Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогын ажилд бурхан шүтээнийг цэвэрлэгээ арчилгаа, тоолсон бурхадыг гүнгэрваанд нь дэгийн дагуу буцаан залж байршуулах, урд өмнө нь бүртгэлд тусгагдаагүй дурсгалуудыг шинээр бүртгэх зэрэг ажиллагаануудад нэлээдгүй цаг хугацаа, хүн хүч зарцуулагдаж байлаа.

Бурханы шашны холбогдолтой монголын түүх, соёлын дурсгал зүйлс төвлөрөн хадгалагдаж байгаа Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогыг явуулахад төрөөс хөрөнгө санхүү, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэн хийдийн захиргаатай хамтран ажиллаж улсын тооллогыг үр дүнтэй зохион байгууллаа.

Гандантэгчэнлин хийдийн Улсын тооллогын комисс нь ССАЖ-ын сайдын 2013 оны А/117 тоот тушаалын нэгдүгээр хавсралтад заасан зорилго, зорилтуудыг бүрэн ханган биелүүллээ./Ажлын дэлгэрэнгүй тайлан бичигдэж байгаа болно/

1.8. “Улсын болон аймаг орон нутгийн музейнүүдээс “RCH” бүртгэлийн програмын дагуу музейн үзмэрийн бүртгэлийг хүлээн авах

2006 оноос эхлэн улс, аймгийн музейнүүдийн БМСангаас ирүүлдэг үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийг “RCH буюу Registration of Cultural Heritager” бүртгэлийн програмаар УНБМСанд хүлээж авч байна. УНБМСангаас музейнүүдийн бүртгэн баримтжуулалтыг эрчимжүүлэхэд музейн үзмэрийн тоон дүнгээс хамаарч 10,000 хүртэл үзмэртэй музей жилд 1200 /улиралд 300/, аймгуудийн музей 800 /улиралд 200/ үзмэрийн бүртгэл ирүүлж байхаар график гарган ажилласан.

RCH бүртгэлийн програм нь нэг үзмэрийн талаарх мэдээллийг 36 асуулгын дагуу дэлгэрэнгүйгээр авдаг. Музейн ажилтнуудын тоо, бүртгэл хийх хүний нөөцийн байдал, тухайн музейн үзмэрийн тоо, судлагдсан байдал зэргээс хамаарч музейгээс УНБМСанд ирүүлэх бүртгэлийн тоо жилд харилцан адилгүй байна. Улсын тоолого явагддаг жилд музейн тооллогод голлон анхаарч хүний RCH бүртгэлээ ирүүлэх нь багасдаг.

2012-2013 оны улсын тооллогоор УНБМСангаас Register бүртгэлийн програмаар музейнүүдийн бүх үзмэрийн бүртгэлийг ерөнхий дэвтрийн бүртгэгдсэн байдлаар хүлээн авсан байгаа. 2016 онд бид RCH бүртгэлийн програмыг Register програмтай холбон нэгтгэх ажлыг хийхээр бэлтгэж байна. Ингэсэнээр УНБМСанд улсын хэмжээний музейн үзмэрийн бүртгэлийн анхан шатны мэдээллийг бүрэн бүрдүүлж чадна.

2014 онд **46164**дэсийн **111507**ширхэг үзмэр бүртгэгдсэн байна.

№	Байгууллагын нэрс	УНБМСанд нийт бүртгэгдсэн		2014 онд бүртгэгдсэн	
		Дэс	Тоо ширхэг	Дэс	Тоо ширхэг
1	Богд хааны ордон музей	4099	12964	10	8874
2	Чойжин ламын сүм музей	1115	6149	0	0
3	Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей	2293	2429	47	72
4	Монголын үндэсний музей	4249	6660	941	1099
5	Байгалийн Түүхийн музей	1332	1335	65	68
6	Эрдэнэ Зуу музей	1200	2359	0	0
7	Уран Зургийн галерей	1619	1642	0	0
8	Монголын Театрын музей	3504	4037	0	0
9	Монгол Улсын үндэсний номын сан	630	1122	0	0
10	БХЯ-ний харьяа Монголын цэргийн музей	314	314	0	0
11	ШУА-ийн харьяа Палеонтологийн төв	67	69	0	0
12	ШУА-ийн Археологийн хүрээлэн	759	2447	432	480
13	Улаанбаатар хотын музей	407	611	0	0
14	Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчинлэн хийд*	0	0	0	0
15	Архангай аймгийн музей	1314	6367	362	4621
16	Баян-Өлгий аймгийн музей	883	1890	5	119
17	Баянхонгор аймгийн музей	1710	5256	121	1460
18	Булган аймгийн музей	1915	3345	403	1072
19	Говь-Алтай аймгийн музей	1591	9423	195	7892
20	Говьсүмбэр аймгийн музей	424	424	0	0
21	Дархан-Уул аймгийн музей	866	866	0	0
22	Дорноговь аймгийн музей	805	6643	179	5523
23	Дорнод аймгийн музей	1442	3317	39	92
24	Дундговь аймгийн музей	1177	4230	530	3573

25	Завхан аймгийн музей	1260	1260	0	0
26	Орхон аймгийн музей	610	611	0	0
27	Өвөрхангай аймгийн музей	516	990	0	0
28	Өмнөговь аймгийн музей	942	742	29	223
29	Сүхбаатар аймгийн музей	343	343	0	0
30	Сэлэнгэ аймгийн музей	1007	2934	0	1909
31	Төв аймгийн музей	1487	1824	0	0
32	Увс аймгийн музей	1646	3547	701	903
33	Ховд аймгийн музей	192	80	0	112
34	Хөвсгөл аймгийн музей	1799	3861	0	0
35	Хэнтий аймгийн музей	1288	7326	19	6234
36	Төрийн Түүхийн музей	645	645	0	0
38	Хөшөө цайдам музей	126	173	0	0
39	Хархорум музей	581	2656	136	2099
40	Данзанравжаа музей	7	7	0	0
	Нийт	46164	111507	4214	44795

* Гандантэгчэнлин хийдийн сан хөмрөгийн бурхан шүтээн, эд өлгийн бүртгэлийг энэ 2013-2014 оны улсын тооллогоор “Gandan Data” бүртгэлийн програмаар авч байгаа болно.

1.9 Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэх ажлыг сайжруулахад музейг заавар, зөвлөмжөөр хангах

Тус төвөөс соёлын биет болон биет бус өвийн чиглэлээр бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, соёлын өвийг хамгаалахад музейн ажилтнууд ССАЖГ-ын мэргэжилтнүүд, Соёлын төвийн эрхлэгч нарт мэргэжил арга зүйгээр хангах сургалтыг 2014 оны 05 дугаар сарын 03-наас 09-ны өдрүүдэд Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгийн ССАЖГ, музей дээр биечлэн очиж зохион байгууллаа.

Дээрх аймгуудад зохион байгуулсан сургалтын зорилго нь Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Соёлын өвийн бүртгэл- мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд соёлын өвийг бүртгэх тухай журам”-д заасны дагуу соёлын өвийг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангахад чиглэгдсэн болно.

Сургалтанд дээрх аймгуудын музейнүүдийн бүртгэл-мэдээллийн санч, сан хөмрөгч, эрдэм шинжилгээний ажилтан, тайлбарлагч, сумын соёлын төвийн эрхлэгч

нар болон аймгуудын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, ССАЖГ-ын соёл хариуцсан мэргэжилтэнгүүд тус тус оролцлоо.

Музейн бүртгэл-мэдээллийн санд соёлын өвийн бүртгэл нь цаасан суурьтай болон цахим хэлбэрээр цуглагдан хадгалагдаж байна. Соёлын өвийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж, мэдээллийн сангийн ашиглалт, эрэлт хайлтыг хялбар болгоход уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллээ архивлан хадгалах тал дээр хангалтгүй байна. Сургалтаар тус төвийн мэргэжилтнүүд доорх сэдвээр мэргэжил, арга зүйн хичээлүүдийг заалаа. Үүнд:

- Музейн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлт: /Д.Нарантуяа. Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга/
- Сумдын нутан дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай: /Г.Анхсанаа Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн/
- Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах тухай: /Ж.Насанжаргал. Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн/
- Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагаа, танилцуулга: /Ц.Жаргалсайхан. Биет бус өвийг хамгаалах хэлтсийн дарга/
- Бүртгэл-мэдээллийн санд шаардлагатай техник тоног төхөөрөмж болон соёлын өвийн бүртгэлийн “RCH” програм хангамжийн ашиглалт: /Ж.Даваацэрэн. Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн програмист/ сэдвүүдээр тус тус хичээлүүдийг заасан.

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСЭЭС ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТЭЭР ХИЙСЭН АЖЛУУД:

Боловсруулсан ажлын талаар

- 2014 оны эхний улиралд “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр-II” -ийг боловсруулах ажлыг захирал Г.Энхбат, хэлтсийн дарга Д.Нарантуяа, програмист Б.Алтансүх нар хийж гүйцэтгэн, ССАЖ-ын яаманд хүлээлгэн өгсөн.
- 2015 онд орон даяар явуулах түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын бэлтгэл ажлын хүрээнд үзлэг тооллогод хамрагдах дурсгалын

бүртгэлийн маягт болон төрөл зүйлийг боловсруулсан, бүртгэлийн программын ерөнхий зарчмыг үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, програмист Б.Алтансүх нар боловсруулсан.

- Хэлтсийн мэргэжилтэн Б.Цолмон Дорнод аймгийн Цагаан-овоо сумын нутагт орших Хэрлэнбарс дурсгалыг хамгаалах, сэргээн засварлахаар Соёлын өвийн төв, БНХАУ-ын Соёлын өвийн академи харилцан тохиролцсоны дагуу хамтран ажиллах гэрээг гарын үсэг зурах түвшинд Монгол, Англи дээр боловсруулсан.
- Тус оны 06 дугаар сард Соёлын өвийг хамгаалах тухай хууль шинэчлэгдэн энэ оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан ССАЖ-ын яамнаас үүрэг болгосний дагуу “Соёлын өвийн үзлэг тооллого хийх тухай” журмын эхийг хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Г.Анхсанаа, Музейн холбооны тэргүүн Д.Цэдмаа нар, “Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх” журмын эхийг хэлтсийн дарга Д.Нарантуяа, Монгол банкны ажилтан Г.Сэр-Одын хамт тус тус боловсруулан мөн оны 07 дугаар сард ССАЖ-ын яаманд хүлээлгэн өгсөн. Мөн хуулийн Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, сэргээн засварлах үйл ажиллагаа, хуулбар хийхтэй холбоотой журмуудын анхны төслийг Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, хэлтсийн дарга С.Чинзориг, мэргэжилтэн Б.Алтансүх нар боловсруулан хүлээлгэн өгөв.
- Монгол улсын музейн хууль”-ийн төсөлд боловсруулж байгаатай холбогдуулан тавдугаар бүлгийн “Музейн цуглуулга, бүрдүүлэлт, бүртгэн баримтжуулалт, үзлэг тооллого” хэсэг, “Санхүүжилт”-ий анхны хувилбарыг, Соёлын өвийг хамгалах тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдон “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах уг санд бүртгэх” журмын төслийг захирал Г.Энхбат, мэргэжилтэн Ш.Энхтуяа боловсруулан яаманд хүлээлгэн өглөө.

Хөдлөх болон үл хөдлөх дурсгалын бүртгэл баримтжуулалт, цахим мэдээлэл

- 2014 оны I ба II дугаар улиралд Улаан хэрэмийн шороон бумбагар дурсгалын 3D point cloud мэдээллийг боловсруулах ажил, Музейн үзмэрийн ерөнхий бүртгэлийн Register програмын хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд музейнүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх, Гандантэгчинлэн хийдийн ерөнхий

бүртгэлийн програмыг засаж сайжруулах жилийн туршид програмист Б.Алтансүх Ж.Даваацэрэн нар хийж гүйцэтгэсэн.

- 2012-2013 оны музейн үзмэрийн улсын тооллогын хүрээнд Эрдэнэсийн санд хийгдсэн тооллогын бүртгэлийг бүртгэлийн дэвтэрт гараар бичсэнийг Register програмд шивж оруулах ажлыг мэргэжилтэн Б.Цолмон гүйцэтгэв.
- Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Ламтын 1, 2-р хүн чулууг 3D-ээр сканнердан бүртгэн баримтжуулах ажлыг програмист Б.Алтансүх, мэргэжилтэн П.Чинбат нар 2013 оны 06 дугаар сарын 3-10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.
- 2014 оны 08 дугаар сарын 17-28 ны хооронд томилолтоор “Хэрлэн барс” хот дурсгалыг FARO 3D төхөөрөмж ашиглан баримтжуулах, сэргээн засварлахад шаардлагатай судалгааны ажлаар захирал Г.Энхбат, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, програмист Ж.Даваацэрэн, мэргэжилтэн П.Чинбат,нар явж ажилласан.
- Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших Хэрлэн бар дурсгалыг сэргээн засварлах, 3D хэмжилт хийх урьдчилсан тандалт судалгаа 06 дугаар сард, Соёлын өвийн төв, Америкийн Монгол Судлалын төв хамтран соёлын өв, археологи, палеонтологийн дурсгалыг 3д хэмжээст хэлбэрээр бүртгэн баримтжуулах сургалтыг зохион байгуулахад мэргэжилтэн П.Чинбат, Ц.Цолмон, Ж.Даваацэрэн нар оролцон ажиллав.
- Мөн 06-р сард ССАЖ-ын сайдын үүрэг болгосны дагуу Монгол-Германы хамтарсан археологийн малтлагаас гарсан олдворуудыг Үндэсний музейд сан хөмрөгт шилжүүлэхэд 300 гаруй олдворуудад шинэчилсэн үнэлгээг хэлтсийн дарга Д.Нарантуяа нь яамны дэргэдэх Археологи, палеонтологийн музейн баг, Үндэсний музейтэй хамтран хийв.
- БНСУ-ын Үндэсний соёлын өвийн судалгааны хүрээлэн (NRICH)-тэй хамтын ажиллагаа тогтоох, “Барилга архитектурын дурсгалыг 3D-ээр хэмжих, техникийн зураглал хийх” чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлын бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ ажлын хүрээнд тус төвийн архитектурын хэлтсийн дарга Чой Бонг Суг, инженер Жи Сонг Жин нарын хамт үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Т.Эрдэнэцогт, програмист,

Б.Алтансүх, мэргэжилтэн Г.Анхсанаа нар Архангай аймгийн Өлзийт суманд 1 хоног ажиллаж Өөлд бэйсийн хүрээний өнөөгийн байдалтай танилцаж 2015 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

- Тус төвийн эзэмшлийн серверийг холбогдох журмын дагуу “Үндэсний дата төв” ТӨҮГ-ын зориулалтын дата центр-д үнэ төлбөргүй байршуулах бэлтгэл ажлыг хийлээ. Энэхүү ажлын хүрээнд 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр тус төвтэй 14/330 тоот “Сервер, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг зориулалтын өрөөнд байршуулах үйлчилгээний гэрээ”-г байгуулсан бөгөөд сервер төхөөрөмжийг 2014 оны 12 дугаар сарын 20-24-ний хооронд шилжүүлэн байршуулахаар тохиролцлоо.

Сургалт, сурталчилгааны ажил

- Дундговь аймгийн музейнээс хүсэлт тавьсаны дагуу Соёлын өвийн төвийн Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, Г.Анхсанаа нар 2014 оны 03 дугаар сард тус аймгийн ССАЖ-ын газар, аймгийн музей хамтран зохион байгуулсан “Соёлын байгууллагуудын удирдах ажилтаны 2014 оны сургалт, семинар”-т уригдан “Орон нутаг судлах танхимын үзмэрийг бүртгэн баримтжуулах, бүртгэл мэдээллийн сан үүсгэх”, “Сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, хадгалж хамгаалах, бүртгэл мэдээллийн сан үүсгэх” гэсэн сэдвээр хичээл зааж, аймгийн музейтэй хамтран тус музейг түшиглэн “Музейн үзүүлэлт дэглэлт” сэдвээр дадлага хичээл явууллаа. Уг семинарын талаар аймгийн телевиз-д ярилцлага өглөө.
- 2014 оны 05 сард Монгол улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 90 жилийн ойд зориулсан “Монголын музейн хөгжил, шинэчлэл-90 жил” эрдэм шинжилгээний бага хуралд “Музейн бүртгэл тооллогын зарим асуудлууд” сэдвээр илтгэл тавьж, гарын авлагат итгэлээ хэвлүүлсэн, мөн ажлын хүрээнд “Монголын музейн түүхэн замнал” номонд байгууллагын танилцуулга бичсэн.
- Мөн он 05 дугаар сараас эхлэн музейн 90 жилийн ойн хүрээнд хэвлэгдэх “Монголын музейн шилдэг үзмэр” 3 хэсгээс бүрдсэн уг каталогид орж байгаа улс, аймгийн музейн тайлбар тодорхойлолтыг бэлтгэх, боловсруулах ажлыг хэлстийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар ССАЖЯамны

каталогийн номын редакцийн хянасны дагуу завсар хийх, хэвлэлийн компанид хүлээлгэн өгөх зэргээр ажилласан.

Монголын музейн үзмэрийн шилдэг дээжис” гурван цуврал каталогид орох музейн үзмэриүүдийг гэрэл зургийг ялгах ажил Ж.Даваацэрэн, хосгүй үнэт 729 дурсгалын жагсаалтыг Ж.Даваацэрэн, П.Чинбат нар музей тус бүрээр ялган бэлдсэн.

“Монголын музейн үзмэрийн шилдэг дээжис” каталогид орох үзмэрийн дутуу байгаа гэрэл зургийг авах улаанбаатр хотын болон хөдөө орон нутгийн музей дээр хэлтсийн дарга Д.Наратуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа “Гэрэлт аргамж” ХХК –тай хамтран ажилласан. Энэ ажлаар Эрдэнэ-зуу музей дээр 42 үзмэр, Хархорум музей дээр 90 үзмэр, Хөшөө цайдам музей дээр 30 үзмэр нийт 162 үзмэр, эд өлгийн зүйлийн гэрэл зургийг авсан.

- Үндэсний музей тооллого дууссан, тооллогын дүнд 2007 онд сан хөмрөгч байсан Б.Энхбатын хулгайлсан үзмэрийн жагсаалтад орсон 31 үзмэр энэ удаагийн тооллогоорсан хөмрөгөөс олдсон асуудал гарсан тул тооллогын төв комиссын гишүүдийн хамт тус 31 үзмэрийг газар дээр нь тулгах, 2007 оны тооллогын бүртгэлтэй тулгах ажил мэргэжилтэн Ш.Энхтуяа хийлээ. Гандангийн дэнж дээр хувь хүний хашаан дотроос гарсан XIX-XX зуунд холбогдох зоос, ёншоот, мөнгөн ембүү зэргийг ССАЖ-ын яам /хуучин нэрээ/ -наас байгуулсан комиссын гишүүнд орж Үндэсний музейд хүлээлгэн өглөө.
- Монголын музейн холбооноос хүсэлт тависны дагуу мэргэжилтэн Ш.Энхтуяа 2014 оны 10 сард Өмнөговь аймгийн Ханбогд сумын Соёлын төв болон Даланзадгад хотод Оюутолгойн дэмжлэгтэйгээр Монголын урлагийн зөвлөл, Монголын музейн холбооноос зохион байгуулж байгаа сургалтанд “Музейн үзмэрийн бүртгэн, баримтжуулалт”, “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх тухай”, “Шашны үзмэрийг бүртгэх түүний онцлог” сэдвүүдээр хичээл заалаа.

Мэргэжлийн сургалтанд хамрагдан, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн талаар

- Мэргэжилтэн Т.Эрдэнэцогт 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдөр хүртэл Солонгос улсын Соёлын өвийн үндэсний хүрээлэнд Азийн хадгалалт хамгаалалтын сургалт хөтөлбөрт хамрагдан, мэргэжил дээшлүүлэв.

- 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 30-ны хооронд музейн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд БНХАУ-ын Си-Ань хотод тус төвийн захирал Г.Энхбат, мэргэжилтэн Г.Анхсанаа, Хөх Хотын чиглэлд хэлтсийн дарга Д.Нарантуяа нар музейн ажлын туршлага судлах, танилцах аялалд оролцсон.
- Програмист Б.Алтансүх ЮНЕСКО-ын дэргэдэх Байгалийн болон соёлын өвийн сансарын технологийн олон улсын төв (HIST), Дэлхийн тоон систем, зайнаас тандан судлалын хүрээлэнгээс (RADI) хамтран БНХАУ-ын нийслэл Бээжин хотод зохион байгуулсан “Дэлхийн өвийн газруудын хадгалалт хамгаалалт болон менежментэд сансарын технологийг ашиглах нь” сэдэвт олон улсын хоёрдугаар сургалтанд 2014 оны 07 дугаар сарын 01-20-ны хооронд амжилттай оролцлоо.
- Програмист Б.Алтансүх CIDOC болон Техасын Техникийн Их Сургуулийн музейгээс хамтран АНУ-ын Техас мужийн Лүббок хотод зохион байгуулсан музейн бүртгэн баримтжуулалтын зуны сургалтанд 2014 оны 07 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд тус тус амжилттай оролцлоо.
- Мэргэжилтэн Б.Цолмон Япон улсын Нара- хотноо ЮНЕСКО-гийн Ази-Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны газраас зохион байгуулсан “Археологийн дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт, судалгаа, шинжилгээ” сургалтанд хамрагдсан.

Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар:

- Австри улсын Венийн Хэрэглээний урлагийн их сургууль, Соёлын төв хамтран Богд хааны ордон музейг түшиглэн зохион байгуулсан “Даавуу зөөлөн эдлэлийн хадгалалт, хамгаалалт” сургалтын зохион байгуулалтыг хариуцаж ажилласан.
- Америкийн Монгол судлалын төвийн туслалцаатайгаар Америкийн Нэгдсэн Улсын мэргэжилтэн Бенжамин Меэдиртэй хамтран түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн газарзүйн мэдээллийн системийг / GIS боловсронгуй болгох зорилгоор богино хугацааны сургалтыг хэлтсийн программист, үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтарч хийсэн.
- Хоёр жил тутамд Итали улсын Ватикан хот улсын музейгээс зохион байгуулдаг олон улсын хурал, сэргээн засварлагчдын гарын авлагад зориулан Соёлын

өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзоригийн бичсэн “XIII зууны язгууртны дээлний сэргээн засварлалт” мэргэжлийн өгүүлэлийг гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон Англи хэл рүү орчуулж, Ватиканы музейд илгээсэн.

- 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 23-ны өдрүүдэд Итали улсын Ватикан хот улсад зохион байгуулагдсан “Хадгалалт, хамгаалалтын нийгмийн нөлөө” олон улсын хуралд Соёлын өвийн төвөөс (Б.Мягмарсүрэн) тавьсан “Археологийн даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлалт” илтгэлийг даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлагч Б.Мягмарсүрэнтэй гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон хамтран боловсруулж, орчуулгыг Англи хэл рүү хийсэн.
- 2013 оны 10 дугаар сард Булган аймгийн Баяннуур сумын Улаан хэрмийн шороон бумбагар дурсгал дээр ажилласан ЮНЕСКО-гийн хөрс судлаач мэргэжилтэн Клаудио Марготтини ажлын тайлангаа (38 хуудастай) 2014 оны 04 дүгээр сард Монголын талд хүлээлгэн өгснийг гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон Монгол хэл рүү орчуулсан.
- АНУ-ын Смитсоны хүрээлэн, Улаанбаатар хот дахь Америкийн Монгол судлалын төвтэй хамтран “Үл хөдлөх дурсгалын мэдээллийн сан” сэдэвт семинарыг 2014 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Энэхүү семинар, хэлэлцүүлэгт Б.Алтансүх “Монголын түүх, соёлын хөдлөх ба үл хөдлөх дурсгалын цахим мэдээллийн сан”, “Соёлын өвийн 3D баримтжуулалтын ажил” сэдвээр илтгэл бэлтгэж тавьсан.
- Соёлын өвийн төв, Америкийн Монгол Судлалын төв хамтран соёлын өв, археологи, палеонтологийн дурсгалыг 3D хэмжээст хэлбэрээр бүртгэн баримтжуулах сургалтыг 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулан археологи, палеонтологийн дурсгалыг 3D-ээр бүртгэн баримтжуулах арга зүйн зөвлөгөө болон дадлага ажил програмист Ж.Даваацэрэн, мэргэжилтэн П.Чинбат, Ц.Цолмон хийсэн.
- 2014 оны 5 дугаар сарын 18-ны өдөр “МОНГОЛЫН МУЗЕЙН ХӨГЖИЛ, ШИНЭЧЛЭЛ-90 ЖИЛ” эрдэм шинжилгээны хурлын үйл явцыг дүрсжүүлж Ж.Даваацэрэн, П.Чинбат нар зураг авсан.

- Хэрлэн барс дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах төслийн ажил эхэлсэнтэй холбогдуулан шаардлагатай төсөв болон үйл ажиллагааны төлөвлөгөөг орчуулж, БНХАУ-аас 2 удаа мэргэжилтнүүд Монгол Улсад ирж ажиллахад холбогдолтой зохицуулалтыг хийсэн. Мөн 2014 оны 07 дугаар сард Хэрлэнбарс дурсгал дээр БНХАУ-ын Соёлын өвийн академийн орлогч дарга Хоу Вэйдон, Шиан-ийн Архитектурын их сургуулийн профессор Ли Ши Гуан нар анхан шатны судалгаа хийхэд гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон орчуулагчаар ажилласан.
- Соёлын өвийн төвөөс Монгол Улс дахь АНУ-ын Элчин Сайдын нэрэмжит сангийн тэтгэлэгийн хүрээнд шийдвэрлүүлэхээр өргөн барьсан “Их хаадын чулуун хөргийн мэдээллийн сан үүсгэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах нь төслийн материалыг, Монакогийн вант улсын санхүүжилт, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр Булган аймгийн Баяннуур сумын Улаан хэрмийн шороон бумбагарын бунхант булшыг хамгаалах, Монголын талын мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлэх гэж буй “Булган аймгийн Майхан уулын Шороон бумбагарын археологийн дурсгалыг хадгалах, хамгаалах менежмент” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө буюу Монгол Улсын Засгийн Газартай хийх гэрээний орчуулгыг тус тус гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон Англи хэл рүү орчуулсан.

ТУС ХЭЛТСЭЭС ГАРГАЖ БУЙ

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

- Засгийн газрын 2014 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний соёлын өвийг бүртгэн баримжтжуулах 2 дахь шатны хөтөлбөр” хэрэгжилтийн ажил хүлээгдэж байна. Уг хөтөлбөрт өмнөх 2006-2008 хэрэгжсэн хөтөлбөрийг үйл ажиллагаагөргөжүүлэн соёлын биет ба биет бус өвийн БМСан бүрдүүлэлтийг эрчимжүүлэхээр заагдсан байна.
- 2015 онд хийхээр төлөвлөсөн үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого асуудал. Үзлэг тооллого хийгдэхээс өмнө үл хөдлөх дурсгалуудыг хувийн дугааржуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
- Засгийн газрын шийдвэрээр Хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан Г.Занабазарын өөрийн гараар урласан гэх 30 гаруй цутгуур бүтээлүүдийн талаар эрдэмтэн

судлаачдын судалгаа тайлбар яриаг нэгтгэсэн видео дүрс бичлэгийн сан бүрдүүлэх.

- Гадаадад халин гарсан монголын холбогдолтой түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх талаар ажил хийгдэхгүй байгаа. Энэ талаар ямар бодлого, чиглэл баримтлах талаар яамны зүгээс анхаарах шаардлагатай байна.
- Хувь иргэдийн өмчлөлийн соёлын өвийг бүртгэх асуудал удаашралтай, соёлын өвөө бүртгүүлсэн иргэдэд батламж, гэрчилгээ олгох асуудлыг шийдэх. Бүртгүүлсэн иргэд батламж гэрчилгээг өгөх эсэх талаар хамгийн их асуудаг.
- Нурж гэмтэж болзошгүй, эрсдэлд ойрхон байгаа сүм хийдийн цогцолбор барилгуудыг улсаас компани ажил болгон нэн даруй 3-н хэмжээсээр скандах, сүмийн барилгын архитектурын мэдээллийн сан үүсгэх, түүнчлэн хосгүй үнэт зэрэглэлийн үзмэр, хөдөө хээр орших чулуун хөшөө дурсгалуудыг 3-н хэмжээсээр скандах ажлыг өргөжүүлэх шаардлагатай байна.

ХОЁР. Байгууллага (Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

2.1. Лимбэний битүү амьсгааг хойч үед өвлүүлэх сургалтын гарын авлага боловсруулан хэвлүүлэх;

Битүү амьсгаа”, “Нууц амьсгаа”, “Гинжин амьсгаа”, “Цагирган амьсгаа” хэмээн олон янзаар нэрлэсэн нэгэн өв нүүдэлчин Монголчуудын бүтээлч сэтгэлгээ, эрэл хайгуулын үр дүн, амьдралын шаардлагаас урган гарсан ололт юм. Битүү амьсгааны гарал үүсэл нь алт, мөнгөний дархчуулынуурлах арга ухаан, ур чадвартайхолбоотой юм. Монгол дархчууд үнэт болон өнгөт төмөрлөгийн зүйлээр гоёл чимэглэлийн зүйл урлахдаа битүү амьсгааг хэрэглэж иржээ. Нарийн ур дүй шаардсан гоёл чимэглэлийн зүйлсийг урлахдаа галын дөлийг нарийхан зүүний сүвэгч төдий нүхээр үлээж, угхатуу эдийнхээ тодорхой эд хэсэг рүү галаар цоргин хайлуулах, зөөлрүүлэх шаардлага гардаг. Үүний тулд нарийн гуурс амандаа зууж галын дөл рүү амьсгалаа тасалдуулахгүйгээр аль болох урт хугацаандөдөөн үлээх ёстой болдог байна. Амьдралын энэхүү шаардлагаас үүдэн дархан хүн нарийн гуурсаар галын дөл рүү

үлээх явцдаа хамрийнхаа нүхээр агаар хийг зөрүүлэн авч цагирган маягийн эргэлт буй болгох арга олжээ. Уран дархчуудын цагирган битүү амьсгааг лимбэдэх урлагт авч хэрэглэсэн нь хөгжимдөх арга барилд гарсан нэгэн шинэ ололт байсан гэж үзэж болно.

Энэхүү өв нь техник хөгжсөн XXI зуунд дарханы урлал хийх үйлээс бараг устаж, лимбэдэх урлагт уртын дууны онцлог, донж маягийг илэрхийлэн хөгжимдөх аргын нэг болж уламжлагдан эдүгээ үлдсэн боловч нийгмийн чиг хандлага, үнэ цэнэ, үнэлэмж зэрэг олон зүйлээс хамааран хойч үед өвлөгдөх хэрэглэгдэх байдал нь хомсдож байгаа нь ил байна. Иймд энэхүү өвийг устаж үгүй болохоос сэргийлэн хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээний үүднээс судалгаа шинэжилгээ хийх, сургалт, уран бүтээлийг эрчимжүүлэх, өвлөн уламжлагчдийг тодруулах зорилготой ЮНЕСКО-ийн биет бус өвийн жагсаалтад 2011 онд “Монгол уртын дууг хөгжимдөх уламжлалт арга-битүү амьсгаа” хэмээн бүртгүүлсэн билээ.

Битүү амьсгааг судалгаа шинжилгээний олон салбар, чиглэлийн уулзвараас тал бүрээс нь судлан, зөв горимоор зааж, сургаж өвлүүлэх нь энэхүү үнэт өв устаж үгүй болохоос сэргийлэх хамгийн сайн арга болоод байна. Иймд энэхүү үйл ажиллагааны хүрээнд “Битүү амьсгаа, битүү хөгөөр ЛИМБЭДЭХҮЙ” DVD хавсралт бүхий сургалтын гарын авлагыг “Монголын лимбэдчдийн холбоо”-той хамтран эрхлэн гаргасан.

Сурах бичигт лимбэ хөгжмийн түүх, битүү амьсгаа, дөрвөн хурууны битүү хөгөөр хөгжимдөх арга, хурууны хувиарлалт, суралцах арга техник, дасгал, тайлбар, зөвлөмжөөс гадна, мэргэжлийн багшийн DVD хичээл, уртын дууг хөгжимдсөн XX зууны алдарт лимбэч багш, БНМАУ-ын алдарт гавъяат хөгжимчин Лувсандоржийн Цэрэндорж /1908-1989/, МУГЖ Майдарын Дорж /1916-19../, МУГЖ Магсаржавын Бадам /1950-2008/, СТА Должингийн Энхтайван /1955-1996/ болон СУИС-ийн лимбэ хөгжмийн багш СТА Ц.Цэвэгсүрэн, ХБК-ийн лимбэ хөгжмийн багш СТА Г.Нямжанцан, “Түмэн-Эх” чуулгын лимбэч СТА Д.Даваасүрэн, “Улаанбаатар” чуулгын лимбэч Г.Мягмарцэрэн нарын бичлэгийг нотны хамт хавсаргасан болно.

Монгол лимбэний үүсэл гарал, бүтэц, хөгжимдөх арга барил, Уртын дууг хэрхэн хөгжимдөх талаар ноотны жишээ, зурагт тайлбар, DVD бичлэгээр үзэх Лимбэний тухай баримтат кино, дасгалууд зэргийг оруулж өгснөөр бие даансуралцах оюутан залуус, эрдэмтэн судлаачдад чухал хэрэгцээтэй гарын авлага болох бөгөөд хүн

төрөлхтний ховор өвийн жагсаалтад бүртгэгдсэн битүү амьсгааны арга барилын мөн чанарыг ойлгож, зөв эзэмшсэн, соёлын өвөөрөө бахархах олон өвлөн уламжлагчдыг төрүүлэхэд энэхүү гарын авлага тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байна.

2.2. Аман өвийг авран хамгаалах;

Соёл, спорт, аялалжуулчлалын сайдын үүрэггүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/370 дугаартушаалын дагуу аман өвийг авран хамгаалах чиглэлээр эдүгээрд түмний ой ухаанд үлдэж хоцорсон ардын домгийг гулсорных эмжээнд цуглуулах, соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэх, түүнд тулгуурландомгийн сэтгэлгээний уламжлалд дүн шинжилгээхийж, ЮНЕСКО-гийн дэлхийн өвд бүртгүүлэх, хадгалах, нийтийн хүртээл болгох, хойч үед ээвлүүлэх, домгийн баатруудыг монгол хүүхдийн сэтгэлгээнд хоногшуулах, СӨБ болон ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг домгийн шилдэг дээжсээр баяжуулах, сурталчлах, өвлөн уламжлуулах, сэргээн хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, угажилдолон нийтийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “МОНГОЛДОМГИЙН ЧУУЛГАН” аяныг 2014 оны 12 дугаар сарын 01-нээс 2015 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Улс орон даяар зохион байгуулахаар эхлүүлээд байна.

Соёлын биет бүс өвийг бүртгэн баримтжуулах шалгуурууд

1. Домог нь урьд өмнө нийтэд танигдсан боловч, өөрхувилбарыг гаргажирсэн, сонин содон бөгөөд өмнөдэлгэрсэн хэлбэрийг бүрэн бүтэн, утгатаг өлдөр болгосон, түүхэн үйл явдлыг тодруулж, домгийн төрөлзүйлийг баяжуулсан;
2. Домог үлгэрийг аялгуулан хэлэх аялгууны өөрхувилбарыг таниулсан, ямар нэг хөгжмийн зэмсэг ашиглан илэрхийлсэн;
3. Орон нутгийн болон угсаатны бүлгийн өвөрмөц онцлогтой;

Домог ирүүлэх аргачлал

1. Домгийг бичмэлээр А 4 цаасан дээр, 1,5 зайтай, Arial фонтоор бичсэн буюу ярьж хэлж байгаа байдлыг CD, DVD-д буулгасан байж болно;
2. Домог өвлөгч, цуглуулагчийн овог нэр, хаяг, зураг, намтрын мэдээллийг хавсаргаж дараах хаягаар ирүүлнэ; **Соёлын өвийн төв, 20 А байр, Сүхбаатар дүүрэг,**

**Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар 210620 а, Монгол Улс, /Домгийн аян/,
ichfr@monheritage.mn**

3. Цугларсан домгийг орон нутагт сум, дүүрэг, аймаг, нийслэлийн комисс бүртгэнэ. /Аймаг, сумын соёлын төвийн эрхлэгч, монгол хэл, уран зохиол, түүхийн багш, музейн соёлын биет бус өв хариуцсан ажилтан нар орон нутагт орон тооны бус комиссоор ажиллана/;
4. Сумын комисс нь домгийг цуглуулан бүртгэн баримтжуулалт хийсэн тайлангийн хамт Аймаг, нийслэлийн комисст 2015 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлсэн байна;
5. Аймаг, нийслэлийн комисс бүртгэн баримтжуулсан тайлан эххэрэглэгдэхүүний хамт 2015 оны 08 дугаар сарын 01-ний дотор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэдэх Төв комисс ирүүлнэ. Төв комисс нь 2015 оны 11 дүгээр сарын 01-ний дотор аяны үрдүнгийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнд тайлагнана.

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСЭЭС ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ АЖЛУУД

1. «Монгол туулийн өвийг хадгалан хамгаалах, сэргээн өвлүүлэх нь» Төслийн 1-р шатны үйл ажиллагааны талаар

Монгол тууль хайлах уламжлалт урлагийг хадгалан хамгаалах төлөвлөгөө нь нарийн дүн шинжилгээ, судалгаан дээр үндэслэн уламжлалт зан үйлийг сэргээх, үе үеийн залуу өвлөгчдийг төрүүлэх сургалтыг бий болгох, чадавхжуулах, тогтвортой байдлыг хангах зэрэг нэн яаралтай хэрэгцээн дээр тулгуурлан урт хугацааны зорилго агуулан ЮНЕСКО-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ССАЖЯ-ны харьяа Соёлын өвийн төв нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, «Монгол туульчдийн холбоо» төрийн бус байгууллага болон өвлөн уламжлагчидтай хамтран «Монгол туулийн өвийг хадгалах хамгаалах, сэргээн өвлүүлэх нь» төслийг 2013-2016 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Уг төслийн 1-р шатны үйл ажиллагааг 2013 оны хоёрдугаар хагас жилээс 2014 оны нэгдүгээр хагас жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлэв.

Үүнд:

А. Хээрийн судалгаа болон бүртгэл мэдээллийн талаар

A.1. Тууль хайлах урлагийг эзэмшигч өвлөн уламжлагчийг олж тогтоох, бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд Архангай, Увс, Ховд, Баянхонгор аймгуудад очиж туулийг өвлөн уламжлагчидтай уулзаж тухайн ахуй орчинд нэгэр сургалтын хүрээнд бүртгэн баримтжуулсан болно.

Б. Хамгаалалт болон өвлөн уламжлалын талаар

Б.1. Шавь сургалт

Тууль хайлах урлагийн сургалтыг тууль, тууль судлаачдын оролцоотойгоор сургууль, театрууд дээр зохион байгуулах, улмаар мартагдаж үгүй болж буй туулийг дуу дүрсний бичлэгт сэргээн буулгах. Төрийн болон зан үйлийн баяр ёслол зэрэгт хайлах тууль болон түүний дэг жаяг зэрэг тууль хайлах урлагтай холбогдолтой уламжлалт зан үйл, ёс заншилыг нэн даруй сэргээн дэлгэрүүлэх зорилгоор уламжлалт шавь сургалтыг сэргээн зохион байгуулж эхлэв. Чингэхдээ нэг шавь сургагч нь 2-3 өвлөн суралцагчид 1-2 туулийг бүрэн эхээр нь уламжлалт арга барилаар өвлөн уламжлуулах.

В. Олон нийтийн ойлголтыг төлөвшүүлэх, түгээн сурталчлах талаар

В.1. Хэвлэл мэдээллийн бүтээл

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан монгол тууль, түүний ач холбогдлын тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлж, төлөвшүүлэх зорилгоор МҮОНТВ-тэй хамтран нэвтрүүлэг бэлтгэсэн.

В.2. Цуврал ном, хэвлэмэл бүтээгдэхүүн

Төслийн хүрээнд Монголын олон угсаатны бүлгүүдийн туулийг бүрэн эх бичвэр, мөн гадны болон дотоодын судалгааны материалуудыг багтаасан 10 цуврал боть ном боловсруулж хэвлүүлэхээр төлөвлөж эхний 2 ботийг хэвлүүлсэн болно.

Үүнд:

- 2-р боть: “Заяын Гэсэрийн тууж”,

- 3-р боть: “Жангар” /ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран боловсруулсан/

В.3. Монгол туулийн өвийг хадгалж хамгаалах, сэргээн өвлүүлэх онол, практикийн асуудал /Илтгэлийн эмхтгэл 500 хувь/

Алхам алхамаар тууль хайлах урлаг, түүний арга зүйд суралцах бүрэн дүүрэн, боловсронгуй гарын авлага боловсруулах зорилгоор туульчид болон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран тууль хайлах урлагийн уламжлалт арга зүй, уламжлалт арга ухаан зэргийг багтаасан Гарын авлагыг 1000 хувь хэвлүүлэв.

Төслийн 1-р шатны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг 2014 оны 06-р сарын 14-ны өдөр ЮНЕСКО-ийн төв оффист хүргүүлсэн ба 2дугаар шатны санхүүжилт шийдвэрлэгдэх түвшиндээ явагдаж байна.

2. Соёлын өвийн төвийн дэргэдэх Соёлын биет бус өвийн салбар зөвлөлийн шинжээчдийн багуудын хурал

“Соёлын биет бус өв, түүний өвлөгчийг тогтоохүндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 2.2-т Үндэсний зөвлөлийн гишүүд нь дараах чиглэлээр шинжээчдийн 6 багт ажиллана гэж заасныг үндэслэн Соёлын өвийн төвийн захиралын 2014 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/25 тоот тушаалаар “Соёлын өвийн төвийн дэргэдэх Соёлын биет бус өвийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “зөвлөлийн дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар батлан Үндэсний зөвлөлийн гишүүдийг 6 багт хуваасан болно. Үүнд:

1. Эх хэл болон аман уламжлал, илэрхийллүүд
2. Ардын язгуур урлаг
3. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам
4. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи
5. Ардын уламжлалт гар урлал

Соёлын онол, түүх, соёлын менежмент, маркетингийн баг

Соёлын өвийн төвийн дэргэд Соёлын биет бус өвийн зөвлөл байгуулагдснаар салбар зөвлөлийн шинжээчдийн 6 багууд 2014 оны 04 дүгээр сарын 3-наас 05 дугаар сарын 2-ний өдрүүдэд нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй хуралдаж дараах асуудлыг хэлэлцэв:

- Соёлын биет бус өвийн нэр томъёог оновчтой болгох
- Яаралтай болон Үндэсний төлөөллийн бүртгэлд нэмж оруулах аймаг, нийслэлээс ирүүлсэн өвүүдийн саналыг хэлэлцэх
- Нийслэл, аймаг орон нутгаас соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн “Ардын билиг авъяастны Улсын жагсаалт”-д нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчдын тухай хэлэлцэх
- Өвлөн уламжлагчдын статус

- ССАЖЯаманд ирсэн “Шавь сургалт”-ын төслүүд
- Бусад хэлэлцэхасуудлууд

Хурлын нэгдсэн дүгнэлт

“Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл”, мөн “Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д орсон өвийн зүйлүүд нь нэр томъёоллын хувьд учир дутагдалтай, агуулгын давхцал ихтэй, хэт ерөнхий ангилсан зэрэг сул талуудтай байсан тул эдгээр жагсаалтыг дахин шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсон. Салбар зөвлөлийн шинжээчдийн баг нь энэхүү жагсаалтыг дахин шүүж Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн Конвенцийн үзэл санааны дагуу ерөнхий 5 ай савын хүрээнд дараахи байдлаар өвийн зүйлүүдийг ангилан задлаж жагсаав.

1-р ай сав “Эх хэл болон аман уламжлал, илэрхийлэлүүд” нь нийт 87 өвийн зүйлийг 6 ангилалд,

2-р ай сав “Ардын язгуур урлаг” нь нийт 57 өвийн зүйлийг 7 ангилалд,

3-р ай сав “Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам” нь нийт 66 өвийн зүйлийг 10 ангилалд,

4-р ай сав “Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, арга ухаан” нь нийт 31 өвийн зүйлийг 9 ангилалд

5-р ай сав “Уламжлалт гар урлал” нь нийт 73 өвийн зүйлийг 25 ангилалд тус тус хамруулан жагсааснаар нийт 96 өвийн зүйлийг хамруулсан өмнөх жагсаалтыг 314 өвийн зүйл болгож баяжуулсан болно.

3. “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д бүртгэгдсэн цуур хөгжмийн уламжлалт өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулах

“Монгол цуурын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийн уулзалт, зөвлөлгөөнийг 2014 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улаанбаатар, Жаргалант амралтын газар зохион байгуулав. Уг зөвлөгөөнөөр “Монгол цуурын үндэсний хөтөлбөр”-ийн УИХ-д өргөн барих сүүлийн хувилбарыг хэлэлцэж шийдвэрлэж батлуулав.

4. ЮНЕСКО-д илгээсэн СББӨ-ийн талаар

- 2015 онд ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад давтан нэр дэвшүүлж буй “Ботго авахуулах зан үйл” номинацийн тодорхойлолт, баримтат кинонд 60-70 хувийн засвар өөрчлөлт хийж ЮНЕСКО-д илгээв.
- 2009 онд ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол тууль”, “Уламжлалт бүжиг бий биелгээ”, “Монгол цуурын уламжлалт урлаг”-ийн үйл ажиллагааны тайланг оролцогч улсын хүлээсэн үүргийн дагуу 2014 оны 03 дугаар сарын 31-ны дотор ЮНЕСКО-д илгээсэн ба зөвлөмжийн дагуу дахин шинэчлэн баяжуулж 2014 оны 06 дугаар сарын 08-ны өдөр илгээсэн болно.
- Монгол улсаас 2013 онд ЮНЕСКО-гийн “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-д “Уран бичлэг”, Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д “Монгол гэрийн урлал, зан үйл” бүртгэгдсэн билээ. Эдгээр өвүүдийн батламж хүлээх авах ёслолын ажиллагааг ССАЖЯ, ЮНЕСКО-гийн МҮК, Монголын хүүхдийн ордон, Монгол гэрийг хөгжүүлэх үндэсний төвтэй хамтран 2014 оны 05 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулав.
- 2014 оны 11 дүгээр сарын 24-28-нд Парис хотод болсон ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн конвенцийн Засгийн газар хоорондын ээлжит IX хуралдаанаар Монгол улсаас нэр дэвшүүлсэн “Шагайн харваа”-г ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад амжилттай бүртгүүлэхэд тус төвийн мэргэжилтэн Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Удирдамжийн дагуу оролцлоо. Түүнчлэн тус төвийн мэргэжилтэн нь Засгийн газар хоорондын ээлжит IX хуралдаанд оролцсон Илгэх хуудсыг боловсруулан ГХЯ, ССАЖЯ, ЮНЕСКО-ийн МҮК, Франц Улсад суугаа МУ-ын ЭСЯ, СӨТ-д тус тус хүргүүлсэн болно.
- ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Ингэнд ботго авахуулах зан үйл” өвийн зүйлийн баримт бичгийг зөвлөмжийн дагуу шинэчлэн баяжуулах ажлыг 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр боловсруулан хүргүүлсэн болно.

- ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс болон ССАЖЯ-ны байгуулсан хамтран ажиллах Санамжбичгийн дагуу Соёлын биет бус өвийн үйл ажиллагааны тайланг боловсруулсан.

5. Сургалтын ажлын талаар

- “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг төгөлдөржүүлэх нь” сэдвээр Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын соёлын өв хариуцсан мэргэжилтнүүд, музейн ажилтнууд, сумдын соёлын төвийн эрхлэгч /соёл хариуцсан ажилтнууд/-дийг хамарсан сургалт зохион байгуулав. Уг сургалтанд СББӨ-ийг хамгаалах хэлтсийн дарга Ц. Жаргалсайхан “СББӨ-ийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагаа”, мэргэжилтэн Ж. Насанжаргал “СББӨ-ийн Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан, СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг төгөлдөржүүлэх нь” сэдвээр илтгэл тавьж мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.
- 2014 оны 01 дүгээр сард Соёл Спорт, Аялал жуулчлалын яамтай хамтран Кино урлагийн дээд сургуулийн төгсөх курсын оюутнуудад дипломын ажлын сэдэв сонгох үйл ажиллагаанд СББӨ-ийг хамгаалах хэлтсийн мэргэжилтнүүд Соёлын биет бус өв, түүнийг бүртгэн баримтжуулах тухай сургалт зөвлөгөө өгч, улмаар тус сургуулийн оюутнууд соёлын биет бус өвийн хүрээнд нийт 31 сэдвээр богино хэмжээний баримтат кино, теле нэвтрүүлэг хийж гүйцэтгэх болов. Түүнчлэн СББӨ-ийг хамгаалах хэлтсийн мэргэжилтнүүд дипломын сэдэв хамгаалах зөвлөлд оролцсоноор Шувуучлахуй, Монгол гутал, Тэнгэр шинжихүй зэрэг шилдэг 5 киног шалгаруулав.
- ССАЖЯ, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ССАЖГ хамтран 2014 оны 07 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд Галдан Бошгот хааны мэлмий нээсэн 370 жилийн ойн хүрээнд зохиогдсон Олон улсын хөөмэйн III наадамд шүүгч, эрдэм шинжилгээний бага хуралд “Хөөмэй урлаг өнөөгийн нөхцөл байдал” илтгэл тавьж оролцов. Олон улсын хөөмэйн III наадмын үйл ажиллагааны хүрээнд хөөмийн эрдэм шинжилгээний бага хурал нь “Монгол хөөмэйн өлгий нутаг” хэмээн нэрийдсэн Ховд аймгийн Чандмань суманд зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд Монгол улс, ОХУ, АНУ, БНХАУ, Бельги, Франц, Голланд зэрэг орнуудын төлөөлөгчид оролцож,

16судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлсэн ба Олон улсын хөөмэйн III наадмын уралдаан гоцлол төрөлд нийт 40 оролцогчид, хамтлагын төрөлд нийт 12 хамтлаг тус тус өрсөлдөж 2 үе шаттайгаар зохион байгуулав.

- 2014 оны 07 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд ССАЖЯ, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ССАЖГ, Эрдэнэзуу музей хамтран зохион байгуулсан Төв халхын уртын дуучдын наадамд Өвөрхангай, Архангай, Дархан –Уул, Булган, Орхон аймгаас шалгарсан нийт 17 дуучид оролцсон .
- Дархан-Уул аймгийн ССАЖГ-ын санаачлагын дагуу аймгийн Засаг даргын 2014 оны 05 дугаар 08-ны өдрийн 220 тоот “Ардын язгуур урлагийн их наадам зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай” захирамж, тус аймгийн ССАЖГ-ын даргын 2014 оны 04 дүгээр 28-ны 16 тоот “Ардын урлагийн их наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай “ тушаалаар аймгийн Засаг дарга С.Насанбатын ивээл дор Монгол уламжлалт, язгуур соёлын их өв сан болох аман зохиол, язгуур урлагийн төрөл, мартагдаж буй зан үйл, ёслол, баяр наадам, арга технологи, гар урлалын бүтээлүүдээр суралцагч, өвлөн уламжлагч нарыг нээн илэрүүлэх, шинэ залуу авьяастанг тодруулах, нийтэд сурталчлах, залуу хойч үеийнхэнд өвлүүлэх, үндэсний соёл, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Олон ястны Дарханчууд” Ардын урлагийн их наадмыг 2004 оны 09 дүгээр 30-2014 оны 10 дугаар 17-ны хооронд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Уг наадмын 4 орчим цагийн бүтэн бичлэгийг Соёлын өвийн төвийн биет бус өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал, аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санч Г.Энхбаяр нар хамтран хийж аймгийн болон Улсын бүртгэл мэдээллийн санд баримтжуулан авлаа.
- ЮНЕСКО-ийн “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт”-д бүртгэгдсэн Монгол тууль, цуурын уламжлалт урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, шавь сургалт зохион байгуулах зорилгоор цогцлоосон “ХААН ТУУЛЬСЫН ӨРГӨӨ”-нд 2014 оны 12 дугаар сарын 09-н буюу билгийн тооллын өвлийн эхэн сарын 18-нд “Арван гурван Алтай”-г Жилкэрийн удмын 9 дэх үеийн туульч Авирмэдийн Балдандорж бүрэн эхээр нь хайлах ёслолын үйл ажиллагааг Богд хааны ордон музей, Монголын Туульчдын холбоо, Монголын

цуурчдын холбоотой хамтран зохион байгуулж, уг үйл ажиллагааг бүрэн эхээр нь дүрс бичлэгээр баримтжуулж УНБМСанд оруулав.

6. Соёлын биет бус өвийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх ажил

- Боржигин уртын дууныөвөрмөц арвин санг сэргээн сурталчлах, дуулах арга барил, дэг сургуулийг залуу үедээ өвлүүлэн сургах, ардын авьяастнуудыг тодруулах зорилгоор Боржигин уртын дууны бүсийн уралдааныг 2014 оны 10дугаар сарын 09 өдөр Говьсүмбэр аймгийн ЗДТГ, Сүмбэр сумын ЗДТГ, Боржигин чуулгатай хамтранзохион байгуулсан.
- ❖ 5 аймгийн 13 сумдаас нийт 2 насны ангилалд 40 ардын авьяастан, хүүхэд залуучууд оролцсон.
- ❖ Боржигин уртын дууны бүсийн уралдаан Өсвөр нас, Ардын авьяастан гэсэн 2 ангилалаар амжилттай зохион байгууллаа.Соёлын өвийн төвийн биет бус өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал уралдааныбүтэн бичлэгийг хийж Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд баримтжуулсан авсан. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу “Соёлынбиет бус өв, өвлөн уламжлагчдийг бүртгэн, тогтоох”, “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД СУРТАЛЧЛАН АЛДАРШУУЛАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХЭД ОНЦГОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛСАН ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙГ ТОДРУУЛЖ, МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ”, “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ СУРВАЛЖЛАН ОЛОХ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ”-ын төслийг боловсруулсан.
- 2014- 2015 оны “Үндэсний зөвлөлийн хурал”-аар авч хэлэлцэх “СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авьяастны улсын жагсаалт”-д шинээр нэмж оруулах өвлөгчдийн судалгаа, мэдээлэл гаргав.
- СӨТ-ийн БМС-д буй СББӨ-ийн олон төрөл зүйл, СББӨ-ийг өвлөн уламжлагчдын талаарх мэдээллийн сан, статистик мэдээлэл боловсруулах програм хангамжийг боловсронгуй болгох, өвлөн уламжлагчдын мэдээллийг үргэлжлүүлэн оруулж байна.

**ТУС ХЭЛТСЭЭС ГАРГАЖ БУЙ
ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ,ДҮГНЭЛТ**

1. “Монголын уртын дууг хөгжимдөх уламжлалт арга-битүү амьсгаа” өвийн зүйл нь 2011 онд ЮНЕСКО-ийн СББӨ-ийн Яаралтай хамгаалах шаардлагаар өвийн жагсааланд бүртгэгдсэн бөгөөд ЮНЕСКО-ийн СББӨ-ийг хамгаалах Конвенци, Конвенцийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны удирдамжийн дагуу улс орон нь Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсааланд бүртгэгдсэн өвийн зүйлийн хадгалан хамгаалалт, сэргээн амьлуулах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны тайланг 4 жил тутамд тайлагнах үүрэг хүлээсэн байдаг. Энэхүү тайланг МУ нь 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ЮНЕСКО-д хүргүүлэх тул цаашид тухайн өвийн зүйл дээр анхаарч 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллах шаардлагатай. Иймд тус хэлтэсээс 2015 оны Үр дүнгийн гэрээнд Театрын Музейтэй хамтран “Лимбэний битүү амьсгааны урлаг” хэмээх танхимыг өвийн зүйлийн хадгалаж хамгаалах, өвлөн уламжлуулах шавь сургалт, сурталчилгааны зорилгоор олон нийтэд нээн ажиллуулах. Цаашид тус өвийн зүйлийг ЮНЕСКО-ийн Хүн төрлөхтний төлөөллийн жагсаалт руу шилжүүлэх нөхцөлийг хангаж ажилах тал дээр анхаарах.
2. “Монгол домгийн чуулган”-ыаяны ач холбогдол, зорилгыг олон нийтэд таниулан сурталчилах үйл ажиллагааг идэвхижүүлэх, мөн МУИС, МУБИС зэрэг их дээд сургуулиуд, ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн зэрэг холбогдох байгууллагуудын сан хөмрөгт буй судалгааны хэрэглэгдэхүүний хувийг СӨТ-ийн дэргэдэх УБМНСанд шилжүүлэн авах.
3. ЮНЕСКО-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол туулийн өвийг хадгалан хамгаалах, сэргээн өвлүүлэх нь” төслийн хүрээнд явагдаж буй шавь сургалтын 9 сургагч багшийн нэг нь л халх тууль сургаж буй өндөр настай өвлөн уламжлагч буй тул халх туулийн шавь сургалт, сэргээн өвлүүлэх үйл ажиллагаа орхигдож байгааг анхаарах, түүнчлэн МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй “Монголт тууль” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг үндэслэн төв болон зүүн бүсэд 2015 онд тус үндэсний хөтөлбөрийг халх туулийг хадгалан хамгаалах, сэргээн өвлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай тохирч энэхүү үйл ажиллагааг яаралтай эхлүүлэх санал дэвшүүлж байна.
4. Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй нэмэлт үйл ажиллагаа нь цаг хугацаа, төсөв санхүү, боловсон хүчний нөөц зэрэг ихэд тулгуу гарч ирдэг тул цаашид СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутаг, ТББ, иргэдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг Үр дүнгийн гэрээ байгуулахаас өмнө авч уялдаа холбоотой

ажиллах нь тухайн үйл ажиллагааны үр дүнд ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж байна.

ГУРАВ. Байгууллага (Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтэс)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ

Тус хэлтэс 2014 онд улс саймгийн 15 музейн үзмэр сэргээн засварлуулах хүсэлтийн дагуу 201 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах, түүх соёлын нүл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт сэргээн засварлалтын ажлын хүрээнд Дорнод аймгийн Халхгол сумын нутагдахь Их бурхант дурсгалыг сэргээн засварлалтын ажлыг гүргэлжлүүлэх, Булган аймгийн Баяннуурсум Улаан хэрмийн Шороон бумбагар дурсгал дээр цэвэрлэгээ хадгалалт хамгаалалтын ажлыг хийх, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэ цогт сумын Шатар чулуу, Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэл, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны 3 дурсгалт газар байрлуулах танилцуулга самбар хийж, самбаруудыг байрлуулах, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны дурсгалаас хэв авч хуулбарыг хийх ажлуудыг төлөвлөн ажилласан.

Дээрх төлөвлөгөө тажлуудаас 15 музейн 145 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэн сэргээн засварлаж, Их бурхант дурсгалыг сэргээн засварлалт, Улаан хэрмийн Шороон бумбагар дурсгалын цэвэрлэгээ хадгалалт хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэ цогт сумын Шатар чулуу, Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэл, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны 3 дурсгалт газар байрлуулах танилцуулга самбар хийж, самбаруудыг байрлуулах, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны дурсгалаас хэв авч хуулбарыг хийх ажлуудыг

ажлынтөлөвлөгөөнд тусгажгүйцэтгэхээртөлөвлөсөн.

Мөн энэ онд төлөвлөгөөтажлуудаас гадна 5 музейнхүсэлтийн дагуу9 ширхэгүзмэрийг сэргээнзасварлаж, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших “Хэрлэн барс”-ын дурсгалын суваргыг хамгаалах сэргээн засварлахажлынсудалгааныажлыгэхлүүлсэн.2012 онд хийгдсэнмузейнулсынтоололгойнажлынхүрээнд4музейн30 ширхэгүзмэрийнматериалын бүтэц найрлагыг тогтоохсудалгааныажлыгхийсэн.

3.1. Улс, аймгийн 15 музейн 201ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах

2014 ондсоёлынөвийн төвийнсоёлын өвийг хамгаалах, сэргээн засварлаххэлтэснь улс, аймгийн 15 музейн хүсэлтийндагуу201 ширхэг үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлахажил.

№	Байгууллага	Нийт сэргээн засварлах үзмэрийн тоо	Хүлээж авсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагд-аж байгаа үзмэрийн тоо	Сэргээн засварлагд-сан үзмэрийн тоо	Засварт ороогүй үзмэр
1.	Дорно-говьаймгийн музей	2ш	2ш		2ш	
2.	УБИС – Гол мод -2 хүннүгийнолдворууд	27ш	27ш		27ш	
3.	Монголын үндэсний музей	4ш	4ш		4ш	
4.	Баян –өлгий аймгийн музей	8ш	8ш		8ш	
5.	Увс аймгийн музей	1ш	1ш		1ш	
6.	Төваймгийн музей	1ш	1ш		1ш	
7.	Дундговь аймгийн музей	4ш	4ш		4ш	
8.	Хар хорум музей	2ш	2ш		2ш	
9.	Хөвсгөл аймгийнмузей	5ш	5ш		5ш	
10.	Уран зургийн галерей	5ш				
11.	Баянхонгораймгийн музей	3ш	3ш		3ш	
12.	Хэнтийаймгийн музей	8ш	8ш		8ш	
13.	Хан богд сумын соёлынтөв	111ш	111ш	40	60ш	11

14.	Эрдэнэ зуу музей	15ш	15ш		15ш	
15.	Өмнө-говь аймгийн музей	5ш	5ш		5ш	
	Нийт	201ш	196 ш	40	145	11

Улс, аймгийн 15 музейн 201 ширхэг үзмэрээс 196 ширхэг үзмэр хүлээн авч 2014 оны 12 дугаар сарын 26-ны байдлаар 145 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэн, сэргээн засварлаж, 40 ширхэг үзмэрийн цэвэрлэгээ сэргээн засварлалтын ажил хийгдэж, 11 ширхэг үзмэрийн сэргээн засварлах ажил эхлээгүй байна. Уран зургийн галерей 5 ширхэг үзмэрээ ирүүлээгүй болно. Энэ онд сэргээн засварлах ажил нь дуусаагүй 40 ширхэг, сэргээн засварлах ажил эхлээгүй 11 ширхэг үзмэрийн сэргээн засварлалтын ажлын 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгаж эхний улиралд багтаан сэргээн засварлахаар төлөвлөсөн.

3.2 Их бурхант дурсгалыг сэргээн засварлах ажил

2014 онд Их бурхант дурсгалыг бүтээсний 150 жилийн ойнохураанд гол шүтээн Жанрайсэг бурхан, гол шүтээний мөргөлийн тавцанд ээр байрлах зургаан ширхэг Аюуш, Гонгор, Дүртэдагва зэрэг бурхадын сэргээн засварлалтын ажил, Их бурханы гаднаталын чулуун хэрмийн дөрвөн булангийн суварга, хэрмийн үүдэнийд ааман хаалгыг хийж дуусгахаар төлөвлөн ажилласан. 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 07-р сарын 05-ний хооронд явуулсан энхний шатны ажилд Гол шүтээн Жанрайсэг бурханы тэргүүнлагшин, зургаан ширхэг Аюуш, Гонгор, Дүртэдагва бурхадын чулууны сэргээн засварлах ажлыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөн орон нутагт ажиллаж төлөвлөгөөт ажлыг хийж дуусгасан.

Хоёр дахь шатны ажлыг 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2014 оны 09 дүгээр сарын 05-ны хооронд хэрэгжүүлж чулууны засварыг ажил дууссан. Гол шүтээн Жанрайсэг бурхан, 6 ширхэг Аюуш, Гонгор, Дүртэдагва бурхадын өнгө будгийг сэргээн засварлах, гол шүтээний лагшинийг эрлийн чулуун өрлөг, дотор чулуун хүрээний хоёр талын чулуун шат довжоо засварлах ажлыг хийхээрт төлөвлөж төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.

Хэрмэн хашааны хаалга, дөрвөн булангийн суврагыг шинээр хийх ажлын ССАЖ Яам-ныхөрөнгө оруулалтын тендэрт шалгарсан Зэнд мэнэ суварга ХХК – хийж гүйцэтгэсэн болно.

3.3 Булган аймаг Баяннуур сум Улаан хэрмийн цогцолбор дурсгалын ханын зургийг авран хамгаалах ажлын хүрээнд

Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хэрмийн Шороон бумбагар хэмээх газарт орших VI-VII зууны үед холбогдох Түргийн үеийн бунхант оршуулагын байгууламжын хадгалалт хамгаалалтын ажлын хүрээнд 2014 оны 05 дугаар сарын 02-09-ний өдрийн хооронд бунханы дулааллагын хучилтыг нээж, бэхэлгээний модонхийцэд тархсан хөгцмөө гөнцөрийн бохирдолыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улаан хэрмийн Шороон бумбагар дурсгалын бунхант булшныханын зургийн хуулбарыг хийх ажлын хүрээнд бунхан ы дотор талын модон бэхэлгээний цийн гадарт тархсан хөгцмөө гөнцөрийн бохирдолыг цэвэрлэх, ССАЖ Яам-ны хөрөнгө оруулалтаар худалдан авсан 4

ширхэгконтенор хаусыг Улаанбаатар хотоос дурсгалт газар луу тээвэрлэх ажлаар 2014 оны 08 дүгээр сарын 05-наас 14-ний хооронд орон нутагт ажиллав.

2014 оны 09 дүгээр сарын 12-нд ССАЖ-ны сайд Ц.Оюунгэрэл, тус яамны Соёлын өвийн хэлтсийн дарга Ц.Цэндсүрэн, Санхүүхэрөн гө оруулалтын газрын дарган. Тулганарийн бүрэлдэхүүнтэй тусбаг Улаан хэрмийн Шороон бумбагар дурсгалын хадгалалт хамгаалалт өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр очиж танилцаж цаашид яаралтай авахаргах эмжээний талаар санал солилцлов.

2014 оны 09 дүгээр сарын 14-18-ныхооронд Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн сэргээн засварлагч С.Чинзориг, Д.Нямдорж, А. Мөнгөнцоож Япон улсын Киот хотын Сагаих сургуулийн профессор Масаки Нака, Киото хотын түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах эрх бүхий Сайшики Секкей компанийн захирал сэргээн засварлагч Хаяото Ономүра, Кита мүра Рюо нарын бүрэлдэхүүнтэй баг бунханы 2, 3, 4 –р өрхний ханын зургийн дүрслэлийг тусгай зориулалтын РЕД хальсан дээр буулгах ажлыг хийж гүйцэтгэв.

2014 оны 10 дугаар сарын 02-06-ныхооронд тус бунханы дотор талын бэхэлгээний модонхийцэд тархсан хөгцмөө гөнцөрийн бохирдолыг цэвэрлэх, ханын зургийн хуурч хөндийрсөн өнгө будгийг бэхжүүлж засварлах, бунханы дулааллагын хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

3.4. “Түүх, соёлын үл хөдөх дурсгалыг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн ажил

2014 онд “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн ажлынтусгагдсан Баянхонгор аймгийн Эрдэнэ цогт сумын Шатар чулуу, Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэл, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны 3 дурсгалт газар байрлуулах танилцуулга самбар хийж, самбаруудыг байрлуулах, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны дурсгалаас хэв авч хуулбарыг хийх ажлуудыг

гүйцэтгэх төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2015

онд хийх

№	Байгууллага	Метал	Шавар	Мод	Даавуу	Цаас	Тайлбар
---	-------------	-------	-------	-----	--------	------	---------

ажлын төлөвлөгөөнд тусгаж гүйцэтгэхээртөлөвлөсөн.

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХЭЛТСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙН ЭМЭЛТ ЗАХИАЛГААР СЭРГЭЭН ЗАСВАРЛУУЛАХ, МАТЕРИАЛ БҮТЦИЙГ СУДАЛГАА ХИЙЛГЭХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖЛЫН БЭЛТГЭЛ СУДАЛГААНЫ АЖЛУУД

-Дүрслэх урлагийн музей Монгол цэргийн музей, ШУТИС-ийн нийгмийн технологийн сургууль, Гандан хийдийн хүсэлт захиалгындагууяаралтай сэргээн засварлуулах шаардлагатай доорх нэр бүхий 9 ш үзмэрийг сэргээн засварласан.

1.	Гандан хийд				1		Дуйнхор зээгт наамал
2.	Дүрслэх урлагийн музей				2		Цамын дээл 2ш
.3	Монгол цэргийн музей	1					Жуковын одонгийн хуулбар
4.	ШУТИС-ийн нийгмийн технологийн сургууль					5	Хуйлмал цаас хятад бичээстэй
	Нийт	1ш			3ш	5ш	9 ш
№	Байгууллага	Метал	Шавар	Мод	Даавуу	Цаас	Тайлбар
1.	Гандан хийд				1		Дуйнхор зээгт наамал
2.	Дүрслэх урлагийн музей				2		Цамын дээл 2ш
.3	Монгол цэргийн музей	1					Жуковын одонгийн хуулбар
4.	ШУТИС-ийн нийгмийн технологийн сургууль					5	Хуйлмал цаас хятад бичээстэй
	Нийт	1ш			3ш	5ш	9 ш

2012оны музейн үзмэрийн нулсын тооллогын ажлын явцад хэд хэдэн музейн үзмэрт үзмэрийг бүтээсэн материалын нэршлийг нарийвчлан тогтоох шаардлагатай болсноор тухайн үзмэрүүдийн металын найрлагыг шинжилж тогтоохожлыг ССАЖЯам-наас үүрэг болгосон.

Металын бүтэц найрлагын судалгаа хийгдсэн үзмэрүүд

Түүх соёлын дурсгалыг бүтээсэн материалын бүтэцийг судлах судалгааны тоног төхөөрөмүүдийг 2013 онд тустөвд суурилуу лсан. 2014 оноос эхлэн сэргээн засварлагдаж буй археологийн олдворуудад материал бүтэцийн судалгаа хийх, судалгааны үзүүлэлтийн нэгдсэн сан бүрдүүлэх харьцуулалтын өгөгдөлүүдийнх суурь бааз бий болгох зорилгоор Хүннү гол мод-2 -ын 20 ширхэг метал олдворуудад бүтэц найрлагын судалгаа хийсэн

№	Музейн нэрс	Үзмэрийн нэрс	Хийгдсэн ажил
1.	МҮТ- Музей	- Метал эдлэлүүд- 18ш	Металын орц найрлагыг тодорхойлох

		- Мөнгөцөгц-7ш	
2.	Богд хааны ордонмузей		Металынорцнайрлагыгтодорхойлох
3.	Дунд-говь аймгийн музей	- Металэдлэл- 1ш	Металынорцнайрлагыгтодорхойлох
4.	Монгол цэргийн музей	- Метал эдлэл- 4ш	Металынорцнайрлагыгтодорхойлох
5.	Хүннүгомод-2	- Метал эдлэл- 20 ш	Металынорцнайрлагыгтодорхойлох
	Нийт	- 50ш	

1. 2014 онднэмэлт захиалгаар хийгдсэнтүүх, соёлынүлхөдлөхдурсгалуудыгхамгаалахсудалгааныажил

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших “Хэрлэн барс”-ынсуваргаыгхамгаалахсэргээн засварлахажлыгБНХАУ-ынсоёлынбуцалтгүйтусламжынхөрөнгөөр 2015 ондхийгдэх ажлынурьдчилсансудалгааныажлыг2014 оны 07 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэдСоёлын өвийн төвийн Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, мэргэжилтэн П.Чинбат, Ц.Цолмон, Хятадын Соёлын өвийн академийн орлогч захирал Хоу Вэйдон, Ши – ань мужийн Архитектур, инженерийн их сургуулийн профессор Чин Пин нарынбагтусдурсгалдээр мөн,2014 оны 08 дугаар сарын 17-ноос 22 -ны өдрүүдэдСоёлын өвийн төвийн захиралГ. ЭнхбатСоёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн дарга С. Чинзориг, мэргэжилтэн П.Чинбат, Хятадын Соёлын өвийн академийн сэргээнзасварлагч Луй Жианг хөх тоосгоны мэргэжилтэн Донг Гу, мөн дижиталбаримтжуулалтынмэргэжилтэнВэйЛионг нарынбүрэлдэхүүнтэйбагдурсгал дээр ажилласан.

2015 оны5-10 дугаар саруудадтус дурсгалыгхамгаалаххамгаалалтынажлыгхийхээр төлөвлөжбайна.

2. УлаанхэрмийнШороонбумбагарбунхантдурсгалынханынзургийнхуулбар ыгхийхажил

Улаан хэрмийн Шороон бумбагарын бунхант булшны ханынзургийгхамгаалахажлынхүрээнд бунханыэх зургийгхуулжавах ажлыгэхлүүлэхээсөмнө,ханынзургийн хуулбарыг1x1 хэмжээгээрмэргэжлийн төвшиндхийх шаардлагатай гэжүзэжСоёл, спорт аялал жуулчлалын яамнаас 2014 оны улсын төсвийн хөрөнгөөрШороон бумбагарын бунхант булшны ханын зургийнхуулбарынажлыг гүйцэтгэхгүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт

“Түүхийн дурсгалан” ХХК шалгарч, тускомпаны ханын зургийн хуулбарыг хийж гүйцэтгэх ажилд Соёлын өвийн төвийн сэргээн засварлагчид туслан гүйцэтгэгчээр ажиллахыг Соёл, спорт аялал жуулчлалын яамнаас үүрэг болгосны дагуу 2014 оны 08 дугаар 05-наас 2014 оны 12 дугаар сарын 20 – ны хооронд хамтарч ажилласан.

3. Сарьдагын хийдийн тууриас илэрсэн олдворуудыг яаралтай хамгаалтандаа хажил

ШУА –

ын харьяа Түүхийн хүрээлэнгийн судалгааны багийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Сарьдагын хийдийн туурийг малтан судлах археологийн судалгааны ажлын хүрээнд олон тооны шавар, бурхад, малтлагын талбайгаас гарсныг яаралтай хамгаалж цэвэрлэж бэхжүүлэх, баглаасавбоодолхийж зөөж тээвэрлэх ажлыг Соёлын өвийн төвийн сэргээн засварлагчид 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 12-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

4. Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтын аргазүйн сургалт

Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн арга зүйн сургалтын ажлын хүрээнд 2014 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 07-ны өдрийн хооронд Герман улсын Гёте-Институт, Монгол дахь Юнеско-гийн төвтэй хамтарсан “Даавуу болон цаасан баримтыг хадгалан хамгаалж сэргээн засварлах нь”-сургалт семинарт тус төвийн сэргээн засварлагч О. Оюунчимэг Б. Мягмарсүрэн нар оролцсон.

2014 оны 02 дугаар сарын 22-ноос 28-ний хооронд Богд хааны ордон музей, Австри улсын хэрэглээний их сургуулийн хамтарсандаа вууз өөлөн эдлэлийн сэргээн засварлалтын сургалтанд тус төвийн сэргээн засварлагч О. Оюунчимэг Б. Мягмарсүрэн нар оролцсон.

2014 оны 07 дугаар сарын 23-30 хооронд Герман улсын Ландес музейн сэргээн засварлагч мэргэжилтэн гүүд Хархорум музейтэй хамтарсан археологийн олдвор сэргээн засварлах сургалтанд тус төвийн сэргээн засварлагч Д. Нямдорж А. Мөнгөнцоож Б. Мягмарсүрэн нар оролцсон.

2014 оны 11 дүгээр сарын 18-наас 23-ний өдрүүдэд Итали улсын Ватиканы хот улсын Ватиканы музейгээс зохион байгуулсан

“Соёлын өвийн хадгалалт хамгаалалт нийгэмд үзүүлэх нөлөө” сэдэвт олон улсын хуралд сэр­гээн засварлагч Б.

Мягмар сүрэн “Монголын археологийн даавууз өөлөн эдлэлийн сэргээн засварлалт” нэртэй илтгэлийг тавьж оролцсон.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Соёлын өвийн төв нь 2014 онд ССАЖ-ын сайдтай байгуулсан Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2 тусгай арга хэмжээ, 22 бүтээгдэхүүн хийж гүйцэтгэхээс 2 бүтээгдэхүүнээс бусад ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тус төв 2014 онд нийт 28 ажилтантай ажилласан ба соёлын өвийг хамгаалах, үүн дотроо музейн үзмэр, хээр хөдөө орших хөшөө чулуун дурсгалыг сэргээн засварлах, музейн үзмэрийн улсын тооллого, бүртгэн баримтжуулалт, соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулалт, ЮНЕСКО-д дэлхий өвд бүртгүүлэх, тайлан илгээх зэрэг соёлын биет болон биет бус бүхий л чиглэлээр дагнан ажиллаж байгаагийн хувьд ажлын ачаалал маш ихтэй, хүн цаг боловсон хүчний хувьд шахуу хүрэлцээ муутай ажиллалаа.

2014 онд хийгдэх ёстой ч биелэгдээгүй 2 ажил байгаагийн нэг нь, Үр дүнгийн гэрээний 1.4 дэх хэсэгт буй “Завхан аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгал” цувралын XI дэвтэр, 3.4 дэх хэсэгт буй “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хөтөлбөр”-ийн ажил болох Говь-алтай, Завхан аймгийн нутагт байруулах түүх, соёлын дурсгалт газрыг танилцуулах чулуун самбар хийх, байрлуулах ажил байлаа. Гэрэл зургийн каталог хэвлүүлэх ажил нь 2014 оны 11 дүгээр сард хийх ёстой байсан энэ үед төсвийн санхүүжилт зогссон, санхүүжилтгүй болсон шалтгааны улмаас, самбар хийлгэх, байрлуулах ажил нь Дорнод аймгийн Их бурхант дурсгалыг сэргээн засварлах ажилд шаардлагатай төсөв ССАЖЯ, Соёл урлаг хөгжүүлэх сангаас санхүүжигдээгүйн улмаас шилжигдэн тус тус хийгдээгүй болно.

Үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлаас гадна 2014 онд тус төвийн Соёлын биет өвийг хамгаалах хэлтэс нэмэлтээр 33 ажил, Биет бус өвийг хамгаалах хэлтэс 6 ажил, Сэргээн засварлах хэлтэс 9 ажил, нийт 48 ажлыг тус тус хийж гүйцэтгэжээ.

Сүүлийн жилүүдэд монголын археологчид археологийн малталт судалгаагаар олон тооны олдвор эд өлгийн зүйлс илрүүлж, тэр бүгдийг газар дээр нь бэхжүүлж, анхан шатны түргэн тусламжийн туслалцаа үзүүлэх, газар нь бэхжүүлэх, авран

хамгаалах, зөөж тээвэрлэх, зориулалтын байр, студи тоног төхөөрөмжөөрсэргээн засварлах зэргээр тухайн жилд байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй, цаг үеийн шаардлагаар нэмэлт ажил тус төвийн Сэргээн засварлах хэлтсийн ачааллыг нэмэгдүүлж байна. 2014 онд Баяннуурын бунхант булшны ханын зургандарга зүйн зөвлөгөө өгөн хамтран ажиллах, Сарьдагийн хийдийн тууриас илэрсэн шавар бурхан, бусад эд өлгийн зүйлсийг авран хамгаалах, Хэрлэн барс хотын суварганы сэргээн засварлалт, Гандантэгчинлэн хийд, ШУТИСургууль, Дүрслэх урлагийн музей, Гол мод 2-ын олдворууд зэрэг олон газраас нэмэлтээр ирсэнажлуудыг дурдаж болно.

Археологийн олдвор, уран зураг, монгол зураг, цаас, арьс шир, чулуун дурсгал сэргээн засварлах мэргэжилтнүүд хамгийн их хэрэгцээтэй байгаа нь ажиглагдлаа. Бид тус төвийг Соёлын өвийн үндэсний төв болгон өргөжүүлэх ажлын төлөвлөгөөнд сэргээн засварлах хэлтэсд шаардлагатай боловсон хүчний судалгааг өгсөн болно.

Мөн зарим музей үүнд, Монголын үндэсний музей, Уран зургийн галерей, Хархорум музей, Богд хааны ордон музей зэрэг томоохон музейд үзмэрийн төрөл зүйлд нь тохируулан төрөлжсөн сэргээн засварлах лабораторын анхан шатны ажлыг хийх эрх өгөх, боловсон хүчин, материал техникийн баазыг бэлдэх хэрэгцээ шаардлага байна гэж бид үзэж байна. Эдгээр музей нь тус төвөөс мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, төвийн хяналтын дор музейн үзмэрийн цэвэрлэгээ, бэхжүүлэлт, анхан шатны сэргээн засварлах ажилбарыг хийж болох юм.

Соёлын биет бус өвийг хамгаалах үйл ажиллагааны хувьд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль, дүрэм журмын хүрээнд хийх ёстой өвийн төрөл зүйлийг шинэчлэх жагсаалтыг хэлэлцэх, батлах, өвийг ЮНЕСКО-д бүртгүүлэх, Соёлын биет бус өвийг бүртгүүлэх, хэлэлцэхтэй холбоотой гадаад арга хэмжээ, хурал зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулах тал дээр дутагдалтай ажиллаж байна. 2014 оны 10-11 сард Францын Парис хотноо зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн ээлжит хуралдаанд монголын тал тус хороонд гишүүний эрхтэйгээр оролцсон ба ССАЖ-ын яамны зөвшөөрсөнөөр тус төвийн мэргэжилтэн А.Саруул хуралд оролцоход шаардлагатай төсөв хөрөнгийг огт гаргаж өгөөгүй, хувийн зардлаар оролцсон болно. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад Соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажлынхаа гүнд орж ажиллах хэрэгцээ шаардлага байна.

Соёлын биет бус өвийн чиглэлээр ямар үйл ажиллагаа явагдаж байгаа талаар дээд байгууллага, тухайн төв хоёрын хооронд мэдээлэл солилцоо дутмаг байна. Ялангуяа СББӨ-ийн Үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэх, өвлөн уламжлагчдын шавь сургалтууд зэрэг үйл ажиллагаануудыг нэгтгэхэд хүндрэл гарч байна.

Санал

2014 онд Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Худалдан авах ажиллагааны газраас Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Буянт ухаад байрлахтус төвийншинэ зориулалтын барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэл 60 хувьтай явж байна.2015 оны төсөвт уг барилгыг ашиглалтанд оруулахаар тодорхой төсөв батласан ба шинэ барилгыг ашиглалтанд оруулах, үйл ажиллагааны холбогдох төсөв зардлыг тусгах, шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшлын хөрөнгө оруулалт хийх ажлыг эхлүүлэх саналтай байна.

Мөн 2015 оноос тодорхой үе шаттайгаар тус төвийн мэргэжилтэн боловсон хүчнийг аажмаар нэмэх замаар боловсон хүчнээр хангах, Соёлын өвийг хамгаалах хуулийн хүрээнд Соёлын өвийн төв байгууллагын чадавхийг сайжруулах, бэхжүүлэх хэрэгцээ байна.

Музейн үзмэрийн бүртгэн баримтжуулалтад орчин үеийн дэвшилтэт техник технологи ашиглах, 3 хэмжээст скайнер аппаратаар БХОМузейн сан хөмрөгт хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох Занабазарын урлал, хийцийнцутгур бурхадыг скайнердан баримтжуулах, эрдэмтэн судлаачдыг оролцуулсан дүрс бичлэгийн сан үүсгэх ажилд Яамнаас зөвшөөрөл өгч, ажлыг эхлүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Шинээр баригдах Соёлын өвийн төвийн барилгад суурилагдах Соёлын биет бус өвийн хэлтсийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх дуу дүрс бичлэгийн студи, тайзны аппаратурхэрэгслэлийг Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдтай холбогдон, техникийн хамтын ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалт хийх талаар санал солилцох ажлыг зохион байгуулаххэрэгтэй байна.

Хавсралт 1. 2015 онд хэрэгцээтэй байгаа орон тоо, цалингийн төсөв.

Хавсралт 2. СББӨ-д шаардлагатай тоног төхөөрөмж

ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛЫНӨВИЙНТӨВИЙН ЗАХИРАЛ

Г.ЭНХБАТ

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНТУЯА

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ЖАРГАЛСАЙХАН

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ
ХЭЛТСИЙН ДАРГА

С.ЧИНЗОРИГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН САН ХӨМРӨГИЙН ЭРХЛЭГЧ

Б.БУНДХОРОЛ